



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН
ТАЙЛАН
2022

АГУУЛГА

ӨМНӨТГӨЛ

- Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
- Банкны тухай
- Тайлангийн тухай

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

- Бидний оролцоо
- Ногоон банк
- НҮБ-ын ТХЗ-ын хэрэгжилт
- Байгаль орчин, нийгэм, засаглал

БАЙГАЛЬ ОРЧИН

- Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх нь
- Тогтвортой санхүүжилт

НИЙГЭМ

- Олон талт байдал ба оролцоо
- Ажлын тав тухтай нөхцөл ба хөгжил
- Хөдөлмөрийн үйл ажиллагаа ба хүний эрх
- Нийгмийн оролцоо

ЗАСАГЛАЛ

- Компанийн засаглал
- Ёс зүй ба комплайнс
- Мэдээллийн аюулгүй байдал, нууцлал

ХАВСРАЛТ

- SASB индекс
- БОНЗ, тогвортой байдлын тайлагналын удирдамж
- GRI индекс



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Тогтвортой ирээдүйг цогцлоох бидний амлалтад чухал алхам болсон Тогтвортой хөгжлийн анхны тайлангаа танилцуулж байгаадаа баяртай байна.

Банк, санхүүгийн байгууллагууд нь өргөн цар хүрээ бүхий хамтын ажиллагаанд тулгуурлан байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) удирдлагыг түүчээлэх үүрэгтэй гэдэгт бид итгэлтэй байдаг. Иймээс бид тогтвортой хөгжилд хүрэх явц, ололт амжилт, цаашдын төлөвлөгөөг хуваалцахаар анхны Тогтвортой хөгжлийн тайлангаа дотоодын болон олон улсын стандартад уялдуулан гаргалаа. Үүгээр уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол, нийгмийн тэгш бус байдлаас үүдэлтэй сорилтуудыг шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байгааг тэмдэглэхийг бид зорьсон юм.

Тайлан нь тогтвортой хөгжлийг бизнесийн үндсэн стратегид нэгтгэх, уялдуулах талаар бидний хэрэгжүүлсэн ажлууд төдийгүй энэ чиглэлээрх урт хугацааны зорилго, алсын харааг багтаасан болно. Бид эрчим хүчний хэмнэлт бүхий технологи, тогтвортой ус, хаягдлын хэрэглээ, ногоон дэд бүтэц зэрэг төслүүдийг санхүүжүүлэн дэмжсэнээр ногоон эдийн засагт шилжихэд идэвхтэй хувь нэмэр оруулж байна.

Банк нь байгаль орчныг хамгаалахаас гадна нийгмийн тэгш байдал, оролцоог дэмжих чиглэлээр дорвитой алхмуудыг хийгээд байна. Олон нийтийн үйл ажиллагаа болон хүмүүнлэгийн санаачилгуудаар дамжуулан бид иргэдийг чадавхжуулж, санхүүгийн боловсрол олгох, эрүүл мэнд, бизнес эрхлэлтийг дэмжин ажилласан бөгөөд нийгмийн дэвшил, эдийн засгийн хөгжил зэрэгцэн оршдог гэдэгт бид бат итгэдэг.

Цаашлаад, тайлан нь зохистой засаглалын талаар багтаасан бөгөөд бид үйл ажиллагаандаа ёс зүйн дээд хэм хэмжээг баримталж, хариуцлагатай засаглалыг эрхэмлэдэг.

Тогтвортой хөгжил нь тасралтгүй аялал бөгөөд бид нүүрстөрөгчийн ул мөрийг бууруулах, нийгэмд үзүүлэх нөлөөгөө өргөжүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг дэмжихээр шамдан ажиллаж байна. Тогтвортой хөгжлийг цогцлоох үйлсийг бид хамтын ажиллагаа, нэгдмэл хүсэл зориггүйгээр бүтээх боломжгүй гэдгийг дурдахын саауу бидний хүчин чармайлтад үнэлшгүй хувь нэмэр оруулсан ажилтнууд, эрхэм харилцагч болон түншүүддээ гүнээ талархал илэрхийлье. Бид хамтдаа илүү сайн, тогтвортой ирээдүйг бүтээж чадна гэдэгт итгэлтэй байна.

Тогтвортой хөгжилд хамтдаа!

Хүндэтгэсэн,

ХХБ-ны Гүйцэтгэх захирал
О.ОРХОН

БАНКНЫ ТУХАЙ

Худалдаа, хөгжлийн банк (ХХБ) нь 1990 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Монгол улсын банк санхүүгийн салбарын манлайлагч байгууллага юм. Монгол Улсын ууган банк болох ХХБ нь олон улсын стандартад нийцсэн 130 гаруй нэр төрлийн банкны бүтээгдэхүүн болон харилцагчдад ээлтэй банкны үйлчилгээг санал болгож байна. ХХБ нь Монголын санхүүгийн салбарын томоохон тоглогч, шинийг санаачлагч банк юм.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид харилцагчдадаа хүсэл, тэмүүлэлдээ хүрэхэд нь зориулж, хүлээлтээс нь давсан санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт технологиор хүргэнэ.



УРИА

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХАМТДАА

Банкны ажилтнууд, харилцагчид, хөрөнгө оруулагчид зэрэг хүн бүхнийг хөгжил дэвшлийн зүгт хамт алхахыг уриалан дуудах, нэгтгэх, зоригжуулах утгатай.



АЛСЫН ХАРАА

Хөгжиж буй Монголын дэвшил бүхнийг манлайлагч банк байна.

ҮНЭТ ЗҮЙЛС

Бидний харилцагч

Б

C

Customer centric

Үнэлэмжтэй

Ү

R

Recognition

Төгс төгөлдөр

Т

E

Excellence

Эгнэгт нээлттэй

Э

A

Accessible

Эвсэг баг

Э

T

Teamwork

Гүйцэтгэл төгс

Г

O

Outperforming

Чин хүндлэл

Ч

R

Respect



Нийт актив
9.65 их наяд

Дэлхийн **300** гаруй банк,
санхүүгийн байгууллага
корреспондент харилцаа

Нийт
2,179 ажилтан

Ногоон зээлийн багц
53 тэрбум

Цэвэр ашиг
194.25 тэрбум

Нийгмийн зээлийн багц
1.1 их наяд

МУ-ын ТОП-100 ААН-ээс
94 нь банкны урт хугацааны
харилцагч

Байгууллагад олгосон
зээлийн хэмжээгээр зах
зээлийн **43** хувь

Үйл ажиллагааны орлого
412.27 тэрбум

88 ностро данс

ТАЙЛАНГИЙН ТУХАЙ

"Тогтвортой хөгжлийн тайлан 2022" нь Худалдаа, хөгжлийн банкны 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх санхүүгийн жилийн үйл ажиллагааг хамарсан бөгөөд тогтвортой санхүү, байгаль орчин, нийгэм ба засаглал (ESG)-ын хүрээнд банкны хийж гүйцэтгэсэн ажлуудыг тайлагнасан. Тайлан нь 13 сэдвийн хүрээнд, тухайн асуудалтай холбоотой бидний оролцоо, зорилго, стратеги, бизнес болон нийгэмд хамааралтай байдал болон өнөөг хүртэлх ахиц дэвшлийг багтаасан болно.


Энэхүү тайлан нь Sustainability Accounting Standards Board (SASB), БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын удирдамж болон Global Reporting Initiative (GRI) зэрэг тайлагналын тогтолцоо, стандартуудад уялдуулан боловсруулагдсан болно.




ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

БҮЛГИЙН АГУУЛГА


- Бидний оролцоо
- Ногоон банк
- НҮБ-ын ТХЗ-ын хэрэгжилт
- Байгаль орчин, нийгэм, засаглал




Тогтвортой санхүүжилтийн
манлайлагч байгууллага




Жендэрийн манлай
байгууллага



Эмэгтэйчүүдийн карьер
есөлтийг дэмжигч шилдэг
байгууллага



Монгол улсын шилдэг байгаль
орчин, нийгэм, засаглалыг
хэрэгжүүлэгч банк



Монгол улсын шилдэг
нийгмийн хариуцлагатай
банк

4 ЧАНАРТАЙ
БОЛОВСРОЛЫГ
ДЭМЖИХ



57.7 тэрбум

ХХБ-ны боловсролын салбарт
олгосон зээлийн багц

21 мэргэжилтэн

ХХБ-ны хэрэгжүүлж буй төслийн хүрээнд
санхүүгийн салбарын 21 мэргэжилтэн
Тогтвортой санхүүжилтийн ОУ-ын мэргэшлийн
сертификат авахаар суралцаж байна.

8 ЭДИЙН ЗАСГИЙН
ӨСӨЛТ, ЗОХИСТОЙ
ХӨДӨЛМӨРИЙГ
ДЭМЖИХ



89 салбар

Нийт 89 салбар, тооцооны төв, 285 бэлэн
мөнгөний АТМ болон 10,999 ПОС терминалаар
дамжуулан үйлчилгээ үзүүлж байна.

5,643 байгууллага

2022 оны байдлаар нийт 2,706.8 тэрбум
төгрөгийн бизнесийн зээлийн багц бүхий 587
корпоратив харилцагч болон 520.6 тэрбум
төгрөгийн зээлийн багц бүхий 5,056 жижиг
болон дунд бизнес сегментийн харилцагчийн
үйл ажиллагааг санхүүжүүлсэн байна.

5 ЖЕНДЕРИЙН ЭРХ
ТЭГШ БАЙДЛЫГ
ХАНГАХ



Жендэрийн хороо

Банкны хэмжээнд Жендэрийн эрх тэгш
байдлын бодлогын хэрэгжилтийг ханган
ажиллаж байна.

Жендэр нетворкинг клуб

ХХБ-ны Жендэрийн хорооны харьяа
ажилтнуудын сайн дурын клубийг үүсгэн
байгуулж жендэрийн талаарх мэдлэг,
мэдээллийг түгээх, оролцоог хангах
зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

13 УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН
ҮР НӨЛӨӨГ
БАГАСГАХ



Цаасгүй, цахим салбар

Их Наяд - Лайт салбар үйл ажиллагаагаа
эхлүүлснээр ХХБ-ны цахим үйлчилгээнүүдэд
цаасан маяг таар бүртгүүлж байсныг цахим
хэлбэрт бүрэн шилжүүллээ.

ОУ-ын туршлага судлал

ХХБ-ны хэрэгжүүлж буй төслийн хүрээнд ТоС
холбоо болон ОУСК-тай хамтран санхүүгийн
салбарын 34 мэргэжилтнийг хамруулсан,
тогтвортой санхүүжилтийн чиглэлээр олон
улсын туршлага судлах томилолтыг Нидерланд
болон ХБНГУ-уудад зохион байгуулав.

БИДНИЙ ОРОЛЦОО

Банк нь байгаль орчин, нийгэмд ээлтэй, хариуцлагатай үйл ажиллагааг санхүүжүүлж, хүний эрх, хөдөлмөрийн эрхийн хамгаалал болон байгаль орчны менежментийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх шаардлагыг харилцагчдадаа тавьж, нягт хамтын ажиллагааны дүнд харилцагчийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулж ажилладаг.

ГОЛЛОХ ОЛОЛТ, АМЖИЛТУУД

2012

Нидерландын хөгжлийн банк ("FMO")-тай хамтран Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын системийг банкны үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлснээр Монгол Улсдаа тус системийг нэвтрүүлсэн анхны арилжааны банк болов.

2013

- Байгаль орчин нийгмийн хариуцлага (БОНХ)-ын бодлогын хэрэгжилтэд PwC компаниар олон улсын хөндлөнгийн аудит хийлгэв.
- Монгол Улсад анх удаа "Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн форум"-ыг хамтран зохион байгуулав.
- Форумын дараагаар Монголын арилжааны банкууд нийгэм, байгаль орчинд ээлтэй тогтвортой санхүүжилтийн санаачилгыг хэрэгжүүлэх тунхаг бичигт гарын үсэг зурав.

2014-2015

БОНХ-ын хүрээнд эрсдэл өндөртэй зээлүүдэд тавигдах нөхцөл шаардлагуудыг Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК)-ын Гүйцэтгэлийн 8 стандартад нийцүүлэн боловсруулж, байгаль орчин, нийгмийн эрсдэлийн бодлого, журам, зааврууд, зээлийн ажилтны гарын авлага зэргийг шинэчлэн боловсруулав.

2019

- "Жендэрийн эрх тэгш байдлын бодлого"-ыг батлав.
- Бүс ба Зам санаачилгын Ногоон хөрөнгө оруулалтын зарчмуудын гишүүнээр элсэв.
- Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгчдийн холбоонд гишүүнээр элсэж анхны гишүүн банк болов.

2020

- Банк шинэ бүтэц зохион байгуулалтыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж Ногоон санхүүжилтийн алба (НСА)-ыг шинээр байгуулав. НСА нь олон улсын сайн туршлагыг банканд нэвтрүүлэх, төсөл, хөтөлбөрт хамтын санхүүжилт татах чиглэлээр идэвхтэй ажиллаж байна.
- Уур амьсгалын ногоон сан (УАНС)-ийн итгэмжлэгдсэн байгууллага болов.

2021

- ХХБ нь Ногоон зээлийн хөтөлбөр болон Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийн хөтөлбөрт нийт 71.2 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлэв.
- ХХБ нь Монголдоо анхлан "Тогтвортой санхүүжилтийн хүрээ" баримт бичгийг боловсруулж Moody's корпорацийн хараат компани V.E /одоогийн Moody's ESG/-ээр хөндлөнгийн үнэлгээ гаргуулав.
- ХХБ нь анхны "Ногоон санхүүжилтийн форум"-аа НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Монголбанк болон бусад харилцагч, хамтран ажиллагч байгууллагуудынхаа оролцоотойгоор амжилттай зохион байгуулав.
- "Монгол Улсад тогтвортой болон ногоон санхүүжилтийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх Бэлэн байдлын хөтөлбөр"-ийг Монголын тогтвортой санхүүгийн холбоотой хамтран хэрэгжүүлэхээр Уур амьсгалын ногоон сангийн удирдах зөвлөлөөр батлуулав.

НОГООН БАНК

ХХБ нь 2020 онд 30 жилийн ойгоо тэмдэглэсэн түүхэн үйл явдал болсон ба Монгол Улсын хөгжил, дэвшлийг хөтөлсөн, тэргүүлэгч банкны үүргийг гүйцэтгэж ирсэн он жилүүд байсан хэмээн бид дүгнэсэн билээ. Харин ирээдүйн хөгжил дэвшилд тогтвортой, ногоон хөгжлийн чиг хандлага нэн тэргүүний ач холбогдолтой гэдгийг бид ухамсарлаж, цаашид энэ чиглэлээр тэргүүний банк байх зорилгыг дэвшүүлсэн юм.

Монголын нийт арилжааны банкууд 2013 оны 11 дүгээр сард “Монгол Улсын Тогтвортой Санхүүжилт (ТоС) - ийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хамтарсан тунхаг бичигт нэгдсэн нь манай улсын ирээдүйн хөгжилд хэрэгтэй томоохон дэвшил болсныг онцлон тэмдэглэж байна. Арилжааны банкууд нэгдэн ажилласнаар амьдрах орчин болох ус, хөрс, агаарын бохирдол, цаг уурын өөрчлөлт, хүний эрхийг зөрчсөн асуудлуудын эсрэг бат зогсож, байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулах замаар тогтвортой хөгжлийг бий болгох хэтийн зорилго өөд тэмүүлж байна.

ХХБ нь 2020 онд шинэ бүтэц зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа эрхэлж Ногоон санхүүжилтийн алба (НСА)-ыг Олон улсын банкны газрын Гадаад эх үүсвэрийн удирдлага, хяналтын хэлтсийн харьяанд шинээр байгуулсан. НСА нь олон улсын сайн туршлагыг банканд нэвтрүүлэх, төсөл хөтөлбөрт хамтын санхүүжилт татах, Уур амьсгалын ногоон сангийн төсөл, хөтөлбөр боловсруулах чиглэлээр идэвхтэй ажиллаж байна.

Банк нь өөрийн бизнесийн болон дотоод үйл ажиллагааг ногоон эдийн засгийн загварт нийцүүлэн урт хугацаандаа **Ногоон банк** болох, үүний тулд банкны дотоод үйл ажиллагаанаас улбаатай нүүрс хүчлийн хийн цэвэр ялгарлыг тэглэх (**Net-Zero**) болон 2030 он гэхэд **2 тэрбум ам.долларын** тогтвортой санхүүжилтийг бизнес эрхлэгчид, харилцагч нартаа олгох зэрэг хэтийн зорилгуудыг дэвшүүлж, суурь тогтолцоог олон талт хамтын ажиллагааны дүнд бий болгохоор ажиллаж байна.

Мөн тогтвортой санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний цогц экосистемийг хөгжүүлж, тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрээ бодитоор хэмжих болон 2025 он гэхэд банкны үйл ажиллагаандаа уур амьсгалын эрсдэлийн удирдлагын санхүүгийн ил тод байдлын систем (**TCFD**)-ийг цогцоор нэвтрүүлснээр уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой банк болон харилцагчдад нүүрлэж болох эрсдэл, эрсдэлийг урьтаж харснаар бий болох боломжуудыг тодорхойлж ил тод тайлагнах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг чанарын үр дүнд хүрэхээр зорьж байна.



ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙН ХҮРЭЭ

Тогтвортой, ногоон санхүүжилтийг хөгжүүлэх ажлын хүрээнд ХХБ нь 2021 оны 3 дугаар сард Монголдоо анхлан Тогтвортой санхүүжилтийн хүрээ (Sustainability Framework) баримт бичгийг боловсруулан гаргасан. Энэхүү баримт бичигт ногоон болон нийгмийн зээлийн шалгуурыг нарийвчлан тодорхойлон заасан төдийгүй ногоон эх үүсвэрийн ашиглалт, төслийн үнэлгээ ба сонгон шалгаруулалт, тайлагнал болон баталгаажуулалтын үйл ажиллагааг бүрэн зохицуулах боломж бүрдэж байна. Тогтвортой санхүүжилтийн хүрээг бид Олон улсын хөрөнгийн зах зээлийн нийгэмлэг (ICMA)-ээс гаргасан Ногоон бондын зарчим, Нийгмийн бондын зарчим болон Тогтвортой хөгжлийн бондын удирдамжтай нийцэж байгаа эсэх дээр хөндлөнгийн үнэлгээг (Second-party Opinion) амжилттай гаргуулсан Монголдоо анхдагч байгууллага болсон билээ (Хөндлөнгийн үнэлгээг Moody’s –ийн хараат компани болох V.E /Vigeo Eiris/-ээр гаргуулсан).



ШАГНАЛ, УРАМШУУЛЛУУД

2016, 2017, 2019 он

Монголын Тогтвортой санхүүгийн холбоо, Монголбанк болон Олон улсын санхүүгийн корпорацаас ХХБ-ыг тогтвортой санхүүжилтийг хэрэгжүүлэгч “Шилдэг Тос Банк”-аар шалгаруулав.

2021 он

Монголын Тогтвортой санхүүгийн холбоо болон Монголбанкнаас ХХБ-ыг тогтвортой санхүүжилтийг хэрэгжүүлэгч “Онцлох Тос Банк”-аар шалгаруулав.

2018, 2022 он

Монголын Тогтвортой санхүүгийн холбоо, Монголбанк болон Олон улсын санхүүгийн корпорацаас ХХБ-ыг тогтвортой санхүүжилтийг хэрэгжүүлэгч “Шилдэг Тос Банк”-аар шалгаруулав.

2022 он

- Шилдэг ажил олгогч байгууллагуудыг шалгаруулах “Good workplace awards 2022” арга хэмжээгээр ХХБ-ыг “Эмэгтэйчүүдийн карьер өсөлтийг дэмжигч шилдэг байгууллага”-аар тодрууллаа.
- Тос Холбоо, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос хамтран 2022 оноос эхлэн “Жендэрийн Манлай Байгууллага”-г шалгаруулахаар болсон бөгөөд ХХБ нь анхны эзнээр шалгарав.
- Дэлхийд нэр хүнд бүхий Euromoney сэтгүүлийн дэргэдэх Ази, Номхон далайн бүс дэх эдийн засаг, банк, санхүүгийн салбарын мэдээ, мэдээллийг хүргэдэг Asiamoney сэтгүүлээс ХХБ-ыг 2022 оны “Монгол Улсын Шилдэг Байгаль орчин, нийгэм, засаглалыг хэрэгжүүлэгч банк”, “Монгол Улсын Шилдэг нийгмийн хариуцлагатай банк” шагналуудаар тус тус тодруулав.

ХАМТЫН АЖИЛЛАГАА



GREEN CLIMATE FUND



Global Green Growth Institute



MONGOLBANK
CENTRAL BANK OF MONGOLIA



CCRCC
Climate Change Research & Cooperative Centre



ENERGY REGULATORY COMMISSION



Green Investment Principles



CLIMATE INVESTMENT PLATFORM



TOC
МОНГОЛЫН ТОГТВОРТОЙ САНХҮҮГИЙН ХОЛБОО



MRIA
Mongolian Renewables Industries Association



AG Asian Gateway



IRENA
International Renewable Energy Agency



south pole



THE UNIVERSITY OF EDINBURGH



Frankfurt School
of Finance & Management
German Excellence. Global Relevance.



ASIA LEDS PARTNERSHIP



SHAMBALA 2056
ENGINEERING CAMPUS

НҮБ-ЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГООС ДЭМЖИХ ЗОРИЛТУУД



- 4.1** 2030 он гэхэд бүх эрэгтэй, эмэгтэй хүүхдүүд үнэ төлбөргүй, тэгш, чанартай бага болон дунд шатны боловсролыг эзэмшиж, холбогдох, үр дүнтэй эрдэм мэдлэгтэй болсон байх
- 4.3** 2030 он гэхэд бүх эрэгтэй, эмэгтэй хүнд хямд үнэтэй, чанартай техникийн, мэргэжлийн болон дээд боловсрол, түүний дотор их дээд сургуулийн боловсролыг тэгш авах боломжийг бүрдүүлэх
- 4.5** 2030 он гэхэд боловсролын байгууллагад суралцагсдын жендэрийн зохистой харьцааг хангаж, эмээг бүлэг, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, нутгийн уугуул хүмүүс, эмээг бүлгийн хүүхдүүдэд бүх шатны боловсрол, мэргэжлийн сургалтыг тэгш авах боломжийг бүрдүүлэх
- 4.7** 2030 он гэхэд тогтвортой хөгжлийн мэдлэг, тогтвортой амьдралын хэв маяг, хүний эрх, жендэрийн тэгш байдал, энх тайван болон хүч үл хэрэглэх соёлыг төлөвшүүлэх, дэлхийн иргэн байх, соёлын олон янз байдал болон тогтвортой хөгжилд соёлын оруулж буй хувь нэмрийг ойлгуулах мэдүүлэх замаар тогтвортой хөгжлийг хөхүүлэх дэмжихэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг бүх суралцагчдад олгох



- 5.1** Бүх эмэгтэйчүүд, охидыг ялгаварлан гадуурхах явдлыг таслан зогсоох
- 5.5** Улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хүрээнд шийдвэр гаргах бүх үе шатанд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах тэгш боломжоор эмэгтэйчүүдийг хангах
- 5.в** Бүх түвшинд жендэрийн тэгш байдлыг хөхүүлэн дэмжих, бүх охид, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх хүчирхэгжүүлэх зохистой бодлого, хэрэгжиж болох хууль тогтоомжийг батлан сайжруулах



- 8.3** Бүтээмжтэй үйл ажиллагаа, зохистой ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэх, бүтээлч байдал, инновацыг дэмждэг хөгжлийн чиг баримжаатай бодлогыг хөхүүлэн дэмжиж, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох замаар бичил, жижиг, дунд бизнесийг албан ёсны болгож, тэдгээрийн өсөлтийг дэмжих
- 8.10** Хүн бүрт банк, даатгал, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг хүргэж өргөжүүлэх, түүнийг дэмжих дотоодын санхүүгийн институтын чадавхыг бэхжүүлэх



- 13.3** Цаг уурын өөрчлөлтийг багасгах, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох, цаг уурын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, урьдчилан сэрэмжлүүлэх талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлж, хүмүүсийн болон институтын чадавхыг сайжруулах
- 13.a** Эрсдэлийг бууруулах үндсэн арга хэмжээ болон түүний хэрэгжилтийн талаарх ил тод байдлын хүрээнд хөгжиж буй орнуудын хэрэгцээ шаардлагыг хангах, Ногоон цаг уурын сангийн үйл ажиллагааг тус санд хуримтлагдсан хөрөнгийг ашиглан аль болох хурдан бүрэн эхлүүлэх зорилгоор бүх төрлийн эх үүсвэрээс 2020 он гэхэд жил бүр 100 тэрбум ам.долларыг хамтран бүрдүүлэх зорилтын үүднээс НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцыг хэрэгжүүлэхээр хүлээсэн хөгжингүй улс орнуудын үүрэг амлалтыг биелүүлэх

Өнөөгийн хурдацтай өөрчлөгдөж буй ертөнцөд тогтвортой хөгжил нь салбар бүрийн бизнес эрхлэгчдийн хувьд чухал тэргүүлэх чиглэл болоод байна. Хариуцлагатай санхүүгийн байгууллагын хувьд ХХБ-ны үйл ажиллагааг НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудтай (SDGs) уялдуулахын чухалчлан үздэг. Санхүүгийн салбар нь дэлхийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, тогтвортой хөгжлийг ахиулахад чухал үүрэг гүйцэтгэдэг билээ.

2020 оноос хойш ХХБ нь Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг хэрэгжүүлж байгаа ба эдгээрээс дөрөвт нь (Чанартай боловсролыг дэмжих, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, Зохистой хөдөлмөр эрхлэлт ба эдийн засгийн өсөлтийг дэмжих, Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах) онцлон хувь нэмрээ оруулахаар тодорхойлсон.

4 ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ



- ХХБ-ны “Хязгааргүй мөрөөдөл” төслийн хүрээнд 2022 оны байдлаар нийт 53 ерөнхий боловсролын сургууль, их дээд сургууль, цэцэрлэгийн номын санг тохижуулж 180,000 гаруй хүүхэд, залуусын боловсролд хувь нэмэр оруулж байна.
- ХХБ-наас Монголын тогтвортой санхүүгийн холбоотой хамтран УАНС-ийн буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй “Монгол Улсад тогтвортой болон ногоон санхүүжилтийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх Бэлэн байдлын хөтөлбөр”-ийн хүрээнд Монгол Улсын банк болон банк бус санхүүгийн байгууллагуудын нийт 21 ажилтнуудыг тогтвортой санхүүжилт, уур амьсгалын санхүүжилтийн чиглэлээр ХБНГУ-ын Франкфуртын Их Сургуулийн сертификаттай 6 сарын мэргэшүүлэх цахим сургалтад хамруулах ажлыг төслийн зохицуулагч байгууллагын хувьд зохион байгуулж байна.
- ХХБ нь НҮБ-ын Залуу төлөөлөгч хөтөлбөрөөс зохион байгуулсан “Greenify” хакатон арга хэмжээг дэмжин ажиллаж, залуусын мэдлэг туршлагыг нэмэгдүүлэх зорилгоор илтгэл танилцууллаа.
- Тайлант хугацаанд банкны дотоод сургалт, гадаад онлайн сургалт, мэргэжлийн байгууллагын сургалтуудад давхардсан тоогоор нийт 17,500 гаруй ажилтан хамрагдсан байна. Үүнээс тогтвортой хөгжлийн холбогдолтой дотоод сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо 650 гаруй байна. Үүнд:
 - а. Тогтвортой санхүүжилт, уур амьсгалын өөрчлөлтийн сургалт
 - б. Ногоон болон нийгмийн зээлийн сургалт
 - в. Шинэ харилцааны менежерүүдэд Байгаль орчин, нийгмийн хариуцлагын үнэлгээ, Жендэрийн эрх тэгш байдлын бодлогын талаарх сургалт
 - г. ХХБ-ны ажилтнуудын “Gender Networking club” сайн дурын клубын гишүүдэд зориулсан “Жендэрийн мэдрэмжтэй байдал” сургалт
- 2022 оны байдлаар 52 оюутан ХХБ-ны салбар, тоцооны төвд дадлагажиж байна.
- 2022 оны байдлаар ХХБ-ны боловсролын салбарт олгосон зээлийн үлдэгдэл 57.7 тэрбум төгрөг байна.

5 ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ



- ХХБ-ны Жендэрийн хороо үүсгэн байгуулагдсанаар банкны хэмжээнд Жендэрийн эрх тэгш байдлын бодлогын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ХХБ нь үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний хүрээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах замаар эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн үр дүнтэй оролцоог жендэрийн мэдрэмжтэйгээр дэмжихэд хувь нэмэр оруулсаар байгаа билээ. Мөн Монгол дахь эмэгтэй удирдлагатай жижиг, дунд бизнесүүдийг тусгай хөтөлбөр хэрэгжүүлэн дэмжиж байна.
- 2022 оны эцсийн байдлаар Банкны нийт ажилтнуудын 67 хувь нь эмэгтэй, 33 хувь нь эрэгтэй байна. Түүнчлэн Банкны дунд түвшний ажилтнуудын 45 хувь нь эмэгтэй, 55 хувь нь эрэгтэй байна.
- 2022 оны эцсийн байдлаар ХХБ-ны томоохон харилцагч байгууллагуудын гүйцэтгэх захирлуудын 34 хувь нь эмэгтэй, 66 хувь нь эрэгтэй байхад жижиг, дунд бизнесийн сегментийн харилцагчдын гүйцэтгэх захирлуудын 35 хувь нь эмэгтэй, 65 хувь нь эрэгтэй байна. Түүнчлэн, ХХБ-наас бизнесийн зээлийн бүтээгдэхүүн олгосон иргэдийн 73 хувь нь эмэгтэй, 27 хувь нь эрэгтэй байгаа бол банкнаас иргэдийн зээлийн бүтээгдэхүүн олгосон иргэдийн 52 хувь нь эмэгтэй, 48 хувь нь эрэгтэй байна.
- ХХБ-ны Жендэрийн хорооны харьяа “Жендэр Нетворкинг Клуб”-ыг үүсгэн байгуулж жендэрийн талаарх мэдлэг, мэдээллийг түгээх, ажилтнуудын оролцоог хангах зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.



- ХХБ-ны алсын хараа нь хувьцаа эзэмшигчдэдээ үнэ цэнийг бий болгож, олон улсын стандарт нийцсэн банкны үйлчилгээ, бүтээгдэхүүн харилцагчдадаа санал болгодог Монгол Улсын тэргүүлэгч арилжааны банк байх юм. Банкны эрхэм зорилго нь уламжлалт болон дижитал хэлбэрээр харилцагчидтай ойр байж хэрэгцээ шаардлагыг ойлгож, тэдгээрийг хангахад туслахад оршино. Үүнтэй уялдуулан ХХБ нь 2021 онд “КОВИД-19” цар тахлаас улбаатай гэнэтийн эрсдэлийг үр дүнтэй удирдаж чадсан бол үүнээс хойш Монгол Улсын цар тахлын дараах эдийн засгийг сэргээхэд үнэтэй хувь нэмрээ оруулан ажиллаж байна.
- Тухайлбал, 2022 оны байдлаар ХХБ нь бусад арилжааны банкуудтай харьцуулахад өөрийн хөрөнгийн хэмжээ, нийт зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээ зэргээр хоёр дугаарт, нийт хадгаламжийн хэмжээгээр гурав дугаарт эрэмбэлэгдэж байна. Мөн, ХХБ нь МУ-ын бараг бүх томоохон салбар дахь 500 орчим томоохон аж ахуй нэгжид банкны үйлчилгээ үзүүлдэг ба тайлант хугацаанд Япон Улсын Токио дахь төлөөлөгчийн газрыг оруулаад нийт 89 салбар, тооцооны төв, 285 бэлэн мөнгөний АТМ болон 10,999 ПОС терминалаар дамжуулан үйл ажиллагаа явуулж байна.
- 2022 оны эцсээр нийт 587 томоохон харилцагч байгууллагууд нийт 2,706.8 тэрбум төгрөгийн бизнесийн зээлийн үлдэгдэлтэй байгаа бол 5,056 жижиг болон дунд бизнес сегментийн харилцагч нарын зээлийн үлдэгдэл 520.6 тэрбум төгрөг байна. Харин 65,223 иргэн харилцагч нарын зээлийн үлдэгдэл 864 тэрбум төгрөг байна.
- 2020 оноос хойш ХХБ нь иргэдэд зориулсан хэрэглээний ногоон зээлийн бүтээгдэхүүнийг өөрсдийн эх үүсвэрээр гаргаж эхэлсэн ба 2022 оны байдлаар ХХБ нь нийт 4.15 тэрбум төгрөгийн иргэдийн ногоон зээлийн үлдэгдэлтэй байсан ба харин бизнесийн ногоон зээлийн үлдэгдэл нийт 30.45 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх жилээсээ гурав дахин өссөн байна. Мөн 2022 оны байдлаар ХХБ-ны нийгмийн шинж чанартай зээлийн хэмжээ 1.1 их наяд төгрөг байгаа ба энэ нь нийт банкны зээлийн багцаас 24%-ийг эзэлж байна.



- Цаасгүй, цахим технологид суурилсан Их Наяд - Лайт салбар үйл ажиллагаагаа эхлүүлсэн ба ингэснээр ХХБ-ны цахим үйлчилгээнүүдэд цаасан маягтаар бүртгүүлж байсныг цахим хэлбэрт бүрэн шилжүүлээ. Үүнээс гадна банкны дотоод үйл ажиллагааг (оффисын хөрөнгө эзэмшигчийн нэр шилжүүлэх, гэрээ болон бусад баримт бичигт газар, хэлтсүүдээс санал авах, зээлийн хүсэлтэд дүгнэлт гаргах гэх мэт) цахим системд шилжүүлэх замаар цаасны хэрэглээг бууруулж байна.
- 2022 оны 4-р улирлын байдлаар ХХБ-ны ногоон зээлийн багц нийт 52.5 тэрбум төгрөг байна. ХХБ-ны Бизнесийн ногоон зээлийн бүтээгдэхүүнээр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд нь нэг жилд 47,834 тонн CO2e хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах юм.
- ХХБ-ны Shoppu.mn-тэй хамтран хүргэдэг хэрэглээний “Дижитал ногоон зээл”-ийн үйлчилгээгээр тайлант хугацаанд нийт 460 орчим харилцагч эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан бараа, цахилгаан скүүтер зэргийг худалдан авсан байна.
- УАНС-ийн итгэмжлэгдсэн байгууллагын хувьд ХХБ нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох чиглэлийн төсөл, хөтөлбөр тус бүрт УАНС болон олон улсын банк, санхүү болон хөгжлийн байгууллагуудаас хамтын санхүүжилтийг татан хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Эдгээр төслүүд нь Монгол улсын Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилгод хүлэмжийн хийн ялгаралтыг хамгийн өндөр хэмжээгээр бууруулахаар тодорхойлсон Эрчим хүчний үйлдвэрлэл ба хангамж, Хөдөө аж ахуй, Аж үйлдвэрийн салбарууд болон тэдгээрийн ханган нийлүүлэлтийн сүлжээн дэх эдийн засгийн бүхий л салбаруудыг хамарна.
- ХХБ болон Монголын тогтвортой санхүүгийн холбоо хамтран УАНС-ийн буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй “Монгол улсад тогтвортой болон ногоон санхүүжилтийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх Бэлэн байдлын хөтөлбөр”-ийн хүрээнд Монголын тогтвортой санхүүгийн холбоо болон Олон улсын санхүүгийн корпорацийн хамтран Нидерланд улсын Амстердам, Үтрехт, Хааг хотууд болон ХБНГУ-ын Франкфурт хотноо “Монголын банк, банк бус санхүүгийн салбарын ногоон санхүүжилтийн чадавхыг сайжруулах, туршлага судлах” аялал, арга хэмжээг амжилттай зохион байгуулав.
- Green Hour - өдөр бүр 1 цаг гэрлээ унтрааж эрчим хүчээ хэмнэх аянг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.
- ХХБ-ны эрчим хүчний хэрэглээнд тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар аудит хийлгэж, төв байрны зоорийн давхрын гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлэгээр солих, ариун цэврийн өрөөнүүдэд автомат холигч суурилуулах, дулаан алдагдлыг бууруулах зорилгоор засвар үйлчилгээ хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэж, ажилтнуудад эрчим хүчний хариуцлагатай хэрэглээ болон ач холбогдлыг таниулах зарлал мэдээллийг дотоод сувгаар тогтмол хүргэж байна.
- Хүлэмжийн хийг бууруулах зорилгод нэгдсэн Монголын технологи, үйлдвэрлэл, байгальд ээлтэй төслүүдийн оролцсон “Go Zero” арга хэмжээний зохион байгуулалтыг дэмжиж ажиллалаа.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СУРГАЛТ

Ажилтнууддаа зориулан тогтвортой хөгжил, байгаль орчим, нийгэм, засаглалын чиглэлээр тогтмол сургалтуудыг зохион байгуулдаг ба 2022 онд нэг ажилтан 0.7 цагийн тогтвортой хөгжлийн сургалтад хамрагдсан байна. Үүнээс гадна тогтвортой хөгжлийн чиглэлээр ажилтнууддаа тогтмол мэдээ, мэдээллийг дотоод веб, мэйл зэрэг сувгаар хүргүүлж ажилладаг.

ТОГТВОРТОЙ ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭ



Худалдаа, хөгжлийн банк нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хөрс, агаар, усны бохирдлыг үүсгэхгүй, эрчим хүчний эх үүсвэр, байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, өв соёл, ахуй уламжлалаа эрхэмлэсэн ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах үйл ажиллагааг дэмжих зорилгоор давуу эрх олгох бодлого баримтлан ажилладаг ба тус зохицуулалт нь “Худалдаа, хөгжлийн банканд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны заавар”-ын 4.7.7-заалтад тусгагдсан байдаг.

Мөн банк аливаа худалдан авалт хийхдээ үнэ, чанар зэрэг хүчин зүйлийг харгалзан үзэхээс гадна үндэсний үйлдвэрлэгч, эмэгтэй бизнес эрхлэгч болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих худалдан авалт хийхийг зорин ажилладаг.

ТОГТВОРТОЙ ХЭРЭГЛЭЭ



ХХБ нь Эрчим хүчний зохицуулах хороонд жил бүр барилгын эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөг боловсруулан илгээж, хэрэгжилтийг ханган ажилладаг. Банк нь эрчим хүчний хэрэглээндээ тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар аудит хийлгэсэн ба төв байрны зоорийн давхрын гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлгээр солих, ариун цэврийн өрөөнүүдэд автомат холигч суурилуулах, дулаан алдагдлыг бууруулах зорилгоор засвар үйлчилгээ хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэж, ажилтнуудад эрчим хүчний хариуцлагатай хэрэглээ болон ач холбогдлыг таниулах зарлал мэдээллийг дотоод сувгаар тогтмол хүргэж байна.

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН СИСТЕМ

ХХБ нь 2012 онд Нидерландын Хөгжлийн Банк (ФМО)-тай хамтран “Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежментийн систем” (БОНЭМС) хэмээх Монгол Улсын хувьд цоо шинэ ойлголтыг цогцоор нь хэрэгжүүлж эхэлсэн Монголын анхны арилжааны банк болсон юм. Банк нь зээлдэгчийн зээлийн зарцуулалт нь байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө, эрсдэлийг олж тогтоох, үнэлэх, хяналт тавих зорилгоор энэхүү цогц системийг хэрэгжүүлдэг.

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БОДЛОГО, ЗААВАР

БОНЭМС-ийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хөгжүүлэх зорилгын хүрээнд Худалдаа, хөгжлийн банк нь “Байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлого”-ыг 2012 оноос хойш мөрдөж эхэлсэн бөгөөд “Байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлогыг хэрэгжүүлэх заавар”-ыг шинэчлэн боловсруулж, зээлийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг хянаж, үнэлэх үйл ажиллагаандаа мөрдөж хэвшүүлсэн байна. Банк нь тус бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм зааврыг мөрдөн ажиллахаас гадна олон улсын гэрээ хэлэлцээр, протоколын үзэл баримтлал, шилдэг туршлагуудыг хэрэгжүүлж, мөрдөж ажиллахыг зорьдог.

Банкны БОНХ-ын бодлогын зорилго нь харилцагчийн байгаль орчин, нийгмийн эрсдэлүүдийг тодорхойлох, үнэлэх, бууруулах улмаар зээлийн шийдвэр гаргах явцдаа тусган ажиллаж, банкны олгосон санхүүжилт болон харилцагчийн бизнесийн үйл ажиллагаанаас шалтгаалан байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад оршдог. Банкны БОНХ-ын бодлогын, хэрэгжилт, хяналтыг Эрсдэл хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч, түүний удирдлагад байх Зээлийн эрсдэлийн газар хариуцан, банкны өдөр тутмын зээлийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажилладаг. Байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлого, зааврыг хэрхэн хэрэгжүүлэх үүрэг, чиглэлийг Зээлийн эрсдэлийн газрын Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн шинжээчид хариуцан ажилладаг ба зээлийн эрсдэлийн шинжээчид, салбар төвүүдийн зээл хариуцсан ажилтнуудын ажил үүргийн хуваарьт тодорхой оруулж, мөн тэдгээр ажилтнуудыг сургах, тогтмол мэдээллээр хангах тогтолцоог бий болгосон байна.

Банк нь байгаль орчин, нийгэмд өндөр эрсдэл учруулах магадлалтай салбаруудад тусгайлсан санхүүжилтийн бодлого баримталдаг. Эдгээрийг дурдвал:

- Уул уурхайн салбарт баримтлах санхүүжилтийн бодлого
- Барилгын салбарт баримтлах санхүүжилтийн бодлого
- Малын гаралтай түүхий эд материал бэлтгэн нийлүүлэх, боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх салбарт баримтлах санхүүжилтийн бодлого тус тус болно.

ХАРИЛЦАГЧИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭ

ЮУГ?

Зээл хүсэгчийн үндсэн болон санхүүжүүлэх үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага (БОНХ)-ын анхан шатны болон нарийвчилсан үнэлгээ хийж, дүгнэлт гаргахад Монгол Улсын хууль тогтоомж, журам болоод Олон улсын нэгдсэн конвенцуудыг баримталдаг.

ХЭЗЭЭ?

ХХБ-ны “Байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлого” болон түүнийг хэрэгжүүлэх зааврыг баримтлан зээлийн дүн 100 сая төгрөг, зээлийн хугацаа 12 сараас дээш тохиолдолд БОНХ-ын анхан шатны болон нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэнэ.

ХЭН?

Зээлийн эрсдэлийн газарт харьяалагддаг Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн шинжээч нь зээл хүсэгчийн эрхэлж буй үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ, дүгнэлтийг гаргаж зээл олгох процесст саналаа өгч ажилладаг.

ХЭРХЭН?

БОНХ-ын нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэхдээ зээл хүсэгчийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн хариуцлага, чадамж, түүхийг тодорхойлж, үйл ажиллагааны салбарыг олон улсын салбарын стандарттай харьцуулах замаар, харин дүгнэлтийг ОУСК-ын Компанийн гүйцэтгэлийн 8 стандартыг хангаж буй эсэхэд үндэслэж гаргадаг.

Хэрэв байгаль орчин, нийгмийн эрсдэлийн шинжээчийн зүгээс зээл хүсэгчийн эрхэлж буй үйл ажиллагаа байгаль орчин, нийгмийн эрсдэлтэй бөгөөд түүнийг бууруулах боломжтой гэж үзсэн тохиолдолд эрсдэлийг бодитоор бууруулахад чиглэсэн хугацаат нөхцөл, шаардлага тавин эргэн хяналтаар хэрэгжилтийг хянадаг болно. Түүнчлэн зээл хүсэгчийн үйл ажиллагаа байгаль орчин, нийгэмд үнэмлэхүй хэмжээний хор хохирол учруулах болон банкны санхүүжүүлэхээс татгалзсан хориотой үйл ажиллагааны жагсаалтад багтсан тохиолдолд зээлийг олгохоос татгалзах зэрэг арга хэмжээ авдаг зэрэг нь ирээдүйд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлж байгаа хэлбэр юм.

БАЙГАЛЬ ОРЧИН

БҮЛГИЙН АГУУЛГА

- Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх нь
- Тогтвортой санхүүжилт



↓ **47,834 ТОНН CO₂e**

ХХБ нь Бизнесийн ногоон зээлийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлснээс хойш санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд нь нэг жилд 47,834 тонн CO₂e хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах юм.

БИДНИЙ ОРОЛЦОО

УУР АМЬСГАЛЫН НОГООН САН (УАНС)-ЫН ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

УАНС нь хөгжиж буй орнуудын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход хөрөнгө оруулалт хийх, тогтвортой, ногоон хөгжлийг дэмжих дэлхийн хамгийн том сан бөгөөд 2020 онд УАНС-ийн Удирдах зөвлөлийн шийдвэрээр ХХБ нь тус сангийн итгэмжлэгдсэн байгууллага болсон бөгөөд ингэснээр ХХБ тогтвортой, ногоон хөгжлийг дэмжсэн үндэсний хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр тус бүрд 250 сая хүртэлх ам.долларын хөнгөлөлттэй хамтын санхүүжилт олгох боломжтой болсон юм.

Түүнчлэн банк нь тогтвортой санхүүжилтийг хөгжүүлэх зорилгын хүрээнд хэд хэдэн төсөл, хөтөлбөрүүдийг УАНС болон олон улсын байгууллагуудтай хамтын санхүүжилттэйгээр хэрэгжүүлэхээр ажиллаж байна.



БҮС БА ЗАМ САНААЧИЛГА

УАНС нь хөгжиж буй орнуудын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход хөрөнгө оруулалт хийх, тогтвортой, ногоон хөгжлийг дэмжих дэлхийн хамгийн том сан бөгөөд 2020 онд УАНС-ийн Удирдах зөвлөлийн шийдвэрээр ХХБ нь тус сангийн итгэмжлэгдсэн байгууллага болсон бөгөөд ингэснээр ХХБ тогтвортой, ногоон хөгжлийг дэмжсэн үндэсний хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр тус бүрд 250 сая хүртэлх ам.долларын хөнгөлөлттэй хамтын санхүүжилт олгох боломжтой болсон юм.

Түүнчлэн банк нь тогтвортой санхүүжилтийг хөгжүүлэх зорилгын хүрээнд хэд хэдэн төсөл, хөтөлбөрүүдийг УАНС болон олон улсын байгууллагуудтай хамтын санхүүжилттэйгээр хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

САЙН ДУРЫН ТҮНШЛЭЛ

- ТУЗ-ын дарга Р.Коппа нь Монголын бизнесийн зөвлөлийн дэргэдэх Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой санхүүжилтийн ажлын хэсгийн дэд даргаар ажиллаж байна.
- Гүйцэтгэх захирал О.Орхон нь "Монголын тогтвортой санхүүгийн холбоо"-ны Удирдах зөвлөлийн дарга болон "Тэрбум мод сан"-ийн Удирдах зөвлөлийн гишүүнээр тус тус ажиллаж байна.
- ХХБ-ны төлөөллүүд Монголын тогтвортой санхүүгийн холбооны "Ногоон зээлийн бодлого, бүтээгдэхүүн хариуцсан зөвлөл" болон "БОНЗ, уур амьсгалын эрсдэл хариуцсан банкны зөвлөл"-д оролцон ажиллаж байна.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙН ХӨТӨЛБӨР








УАНС нь хөгжиж буй орнуудын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход хөрөнгө оруулалт хийх, тогтвортой, ногоон хөгжлийг дэмжих дэлхийн хамгийн том сан бөгөөд 2020 онд УАНС-ийн Удирдах зөвлөлийн шийдвэрээр ХХБ нь тус сангийн итгэмжлэгдсэн байгууллага болсон бөгөөд ингэснээр ХХБ тогтвортой, ногоон хөгжлийг дэмжсэн үндэсний хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр тус бүрд 250 сая хүртэлх ам.долларын хөнгөлөлттэй хамтын санхүүжилт олгох боломжтой болсон юм.

Түүнчлэн банк нь тогтвортой санхүүжилтийг хөгжүүлэх зорилгын хүрээнд хэд хэдэн төсөл, хөтөлбөрүүдийг УАНС болон олон улсын байгууллагуудтай хамтын санхүүжилттэйгээр хэрэгжүүлэхээр ажиллаж байна.



ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙН 8 ЗАРЧИМ

ХХБ нь Монголын тогтвортой санхүүгийн холбооны гишүүдийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах найман зарчмыг ХХБ нь 2015 оноос эхлэн мөрдөж байна. Мөн үүсгэн байгуулагч гишүүний хувьд хагас жил тутам тогтвортой санхүүжилтийн хэрэгжилтийн тайланг хүргүүлж байна.



ХХБ нь Монголын тогтвортой санхүүгийн холбоотой хамтран УАНС-ийн буцалтгүй тусламжаар 2022 оноос эхлэн хэрэгжүүлж буй “Монгол Улсад тогтвортой болон ногоон санхүүжилтийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх Бэлэн байдлын хөтөлбөр”-ийн хүрээнд:

- Монгол Улсын банк болон банк бус санхүүгийн байгууллагуудын нийт 21 ажилтныг тогтвортой санхүүжилт, уур амьсгалын санхүүжилтийн чиглэлээр ХБНГУ-ын Франкфуртын их сургуулийн сертификаттай 6 сарын мэргэшүүлэх цахим хөтөлбөрт сургалтад хамруулах ажлыг төслийн зохицуулагч байгууллагын хувьд зохион байгуулж байна. Уг сургалтад хамрагдсанаар суралцагчид тогтвортой санхүүжилт, уур амьсгалын санхүүжилтийн чиглэлээрх бодлого стратегийг өөрийн байгууллагад нэвтрүүлэх, хэрэгжүүлэхэд шаардлагатай ур чадварыг эзэмших юм.
- Монголын тогтвортой санхүүгийн холбоо, Олон улсын санхүүгийн корпорацитай хамтран Нидерланд улсын Амстердам, Үтрехт, Хааг хотууд болон ХБНГУ-ын Франкфурт хотноо “Монголын банк, банк бус санхүүгийн салбарын ногоон санхүүжилтийн чадавхыг сайжруулах, туршлага судлах” аялал, арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр Монгол Улсын санхүүгийн зохицуулагч байгууллагуудын төлөөлөл, Монголын банкны холбоо, Монголын тогтвортой санхүүгийн холбооны гишүүн арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллага, нийслэлийн хөрөнгө удирдлагын компани, Монголын ипотекийн корпорацитай, Банк санхүүгийн академи, хувийн хэвшил болон судалгаа, зөвлөх үйлчилгээний байгууллагын төлөөллүүд Нидерланд улс болон ХБНГУ-ын нэр хүнд бүхий банк санхүүгийн байгууллагууд, түншлэлүүд, банк санхүүгийн холбоод, хөрөнгө оруулалтын сангуудтай хамтарсан уулзалтуудыг зохион байгуулж эдгээр байгууллагын санхүүжүүлсэн томоохон ногоон төсөл хөтөлбөрүүдтэй биечлэн танилцаж, туршлага судалсан билээ.



ЦААСГҮЙ, ЦАХИМ БОРЛУУЛАЛТЫН ТӨВ - ИХ НАЯД ЛАЙТ САЛБАР

ХХБ нь цаасгүй, цахим технологид суурилсан Их Наяд - Лайт салбар үйл ажиллагаагаа эхлүүлсэн ба ингэснээр ХХБ-ны цахим үйлчилгээнүүдэд цаасан маягтаар бүртгүүлж байсныг цахим хэлбэрт бүрэн шилжүүллээ. Үүнээс гадна банкны дотоод үйл ажиллагааг (оффисын хөрөнгө эзэмшигчийн нэр шилжүүлэх, гэрээ болон бусад баримт бичигт газар, хэлтсүүдээс санал авах, зээлийн хүсэлтэд дүгнэлт гаргах гэх мэт) цахим системд шилжүүлэх замаар цаасны хэрэглээг бууруулж байна.

Тус салбарын онцлог, давуу тал нь:


- Уламжлалт банкны нэгжээс ялгагдах онцлог нь цаас ашиглахгүй, байгальд ээлтэй, цахим, шинэ өнгө төрх бүхий засвар тохижилттой;
- E-Mongolia болон тоон гарын үсэг ашиглан харилцагчийг танин баталгаажуулж, холбогдох гэрээг байгуулдаг;
- Харилцагчийн бүх хүсэлтүүдийг цахимаар авч шийдвэрлэдэг;
- Харилцагчид бэлэн болон бэлэн бус гүйлгээ, байгууллагын үйлчилгээнээс бусад банкны бүх төрлийн үйлчилгээг үзүүлдэг;
- Харилцагч төхөөрөмж дээр хүсэлтээ өөрөө бүртгэж илгээдэг тул мэдээлэл буруу бөглөгдөх эрсдэл бага;
- Харилцагчийн цахим хүсэлт нь банкны холбогдох программд шууд бүртгэгддэг тул ажилтнуудын ажлын ачааллыг хөнгөвчилдөг;
- Харилцагчийн хувийн хэргийн бүрдэл цахим тул ажилтнуудын бүтээмж илүү сайжрах боломжтой;
- Харилцагч тоон гарын үсэг авах боломжтой киоск төхөөрөмж байршуулсан.




ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

Монгол Улс нь 2018 оны 12 дугаар сард Монгол Улсын Тогтвортой Санхүүжилтийн Үндэсний замын зургийг “Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ”, “Ногоон зээл”, “Тогтвортой санхүүжилтийг дэмжих хамтын ажиллагаа, бодлогын орчин” гэсэн 3 ерөнхий бүлэгтэйгээр боловсруулан баталсан юм. Манай улсын хувьд ногоон санхүүжилтийн ойлголт нь ихээр дэлгэрч бүхий л салбарт хөгжиж байгаа бөгөөд банкны салбар нь ногоон санхүүжилтийг дэмжин, ногоон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх санхүүжилтийн бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нэвтрүүлээд багагүй хугацаа өнгөрч байна.

Арилжааны банкуудаас олгосон ногоон зээлийн үлдэгдэл (тэрбум.төг)



Банкны салбарын нийт ногоон зээлийн багцад ХХБ-ны эзлэх хувь



Монгол Улсын хувьд ногоон зээлийн үлдэгдэл нь банкны салбарын нийт зээлийн 1.4 орчим хувийг эзэлж байна. Энэ нь ногоон санхүүжилтийг дэмжих шаардлагатай байгааг харуулж байна.

Зээлийн үлдэгдлийн мэдээллийг ангиллаар нь авч үзвэл тогтвортой хөдөө аж ахуй, газар ашиглалт, ой болон эко аялал жуулчлал бүхий төсөл, хөтөлбөрт 30% буюу 91 тэрбум төгрөг олгогдсон байгаа бол ногоон барилга, тогтвортой ус, хаягдлын хэрэглээ зэрэг ангиллууд нь тус тус 20 орчим хувийг бүрдүүлсэн үзүүлэлттэй байна.

Худалдаа, хөгжлийн банк нь тогтвортой хөгжлийг дэмжин ажиллах хүрээнд тогтвортой болон ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэн харилцагчдадаа санал болгож тэдний тогтвортой үйл ажиллагаа, байгаль орчинд ээлтэй хэрэглээ, сонголтод анхааран ажиллаж байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд Банкаас олгосон ногоон зээлийн багцын хэмжээ жилд дунджаар 27 хувиар өсөж 52.5 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

ХХБ нь Ногоон зээлийн хөтөлбөр, Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийн хөтөлбөрт нийт 71.2 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн бөгөөд эдгээр хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэх үүднээс тогтвортой санхүүжилтийн тусгай бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлсэн юм.

ИРГЭДЭД ЗОРИУЛСАН НОГООН ЗЭЭЛ

ХХБ нь өөрийн эх үүсвэр болон татан төвлөрүүлсэн гадаад эх үүсвэрээр санхүүжүүлэн эрчим хүчний хэмнэлттэй, ногоон бүтээгдэхүүнийг харилцагчдад таатай нөхцөлөөр худалдан авахад зориулан **Эко автомашины зээл**-ийг 2018 онд, **Хэрэглээний ногоон зээл**-ийг 2020 онд, **Цахим ногоон зээл**-ийг 2021 оноос эхлэн зах зээлд нэвтрүүлсэн билээ. Агаар болон хөрсний бохирдлыг бууруулах, иргэдийн эко хэрэглээг дэмжих зорилгоор Шоппи ХХК-тай хамтран нэвтрүүлсэн онлайн зээлийн үйлчилгээнд байгальд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бизнес эрхлэгчид өргөнөөр нэгдэж, өөрсдийн бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд цахим зээлийн таатай нөхцөлөөр хүргэсээр байгаа юм. Эко автомашины зээлийн бүтээгдэхүүнээр шинэ болон үйлдвэрлэгдсэнээс хойш 10 жил дотор насжилттай хос хөдөлгүүрт болон шингэрүүлсэн хийн хөдөлгүүрт автомашин болон цахилгаан авто тээврийн хэрэгслүүдийг хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдан авах боломжтой юм.



ХЭРЭГЛЭЭНИЙ НОГООН ЗЭЭЛ

Байгаль орчин, хөрсний бохирдлыг бууруулах зорилго бүхий эко тодотголтой, чанарын шаардлага хангасан бүх төрлийн бүтээгдэхүүнд олгох зээлийн бүтээгдэхүүн



ЦАХИМ НОГООН ЗЭЭЛ

Эко тодотголтой бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй нөхцөлөөр санхүүжүүлэх, цахим худалдааны платформтай хамтарсан зээлийн бүтээгдэхүүн



ЭКО АВТОМАШИНЫ ЗЭЭЛ


Хосолсон тэжээлт болон шингэрүүлсэн хийн хөдөлгүүрт автомашиныг хөнгөлөлттэй нөхцөлтэй санхүүжүүлэх бүтээгдэхүүн



ЦАХИЛГААН АВТОМАШИНЫ ЗЭЭЛ

100% цахилгаан хөдөлгүүртэй автомашиныг хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдан авах боломжтой зээлийн бүтээгдэхүүн

ХХБ-ны иргэдийн ногоон зээлийн үлдэгдэл, бүтээгдэхүүний төрлөөр (2022 оны IV улирал)



- Эко автомашины зээл
- Хэрэглээний ногоон зээл
- Онлайн ногоон зээл


БИЗНЕСИЙН НОГООН ЗЭЭЛ

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 13 дахь зорилго буюу Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах зорилгыг хэрэгжүүлэхийн тулд урт хугацаатай, хөнгөлөлттэй нөхцөл бүхий ногоон зээлийн бүтээгдэхүүн чухал дэмжлэг болох тул ХХБ нь бизнесийн ногоон зээлийн бүтээгдэхүүнийг 2021 оны 8 дугаар сараас эхлэн хөнгөлөлттэй нөхцөлтэйгөөр зах зээлд нэвтрүүлсэн юм. Бизнесийн ногоон зээлээр санхүүжүүлэх ногоон үйл ажиллагаа, төсөл нь Монгол Улсын Ногоон Таксономи болон ХХБ-ны “Тогтвортой санхүүжилтийн хүрээ” баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтийг хангасан байх шаардлагатай. 2022 оны 4-р улирлын байдлаар ХХБ-ны ногоон зээлийн багц нийт **52.5** тэрбум төгрөг байгаа ба “Монгол Улсын Ногоон Таксономи”-ийн Эрчим хүчний хэмнэлт болон Тогтвортой ус, хог хаягдлын хэрэглээ ангиллуудад харгалзан тус тус 39.2%, 32.8% буюу дийлэнх зээл олгогдсон байна.




ХХБ нь энэхүү бүтээгдэхүүнийг нэвтрүүлснээс хойш санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд нь нэг жилд 47,834 тонн CO2e хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах юм.

ХХБ-ны ногоон зээлийн үлдэгдэл (бизнесийн сегментээр)



ХХБ-ны санхүүжүүлсэн ХХЯ-ын бууралт бий болгох төслүүдийн ногоон таксономийн ангилал



ХХБ нь ногоон төсөл, хөтөлбөрийг баталгаажуулах, төслийн үр дүнг хэмжихдээ Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас санаачлан Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо болон ХХБ-ны оролцоотойгоор South Pole компанийн (Швейцарт төвтэй, нүүрстөрөгчийн санхүүжилтийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг) боловсруулсан хүлэмжийн хийн ялгарлын тооцоолуурыг ашиглаж байна.



НИЙГЭМ

БҮЛГИЙН АГУУЛГА

- Олон талт байдал ба оролцоо
- Ажлын тав тухтай нөхцөл ба хөгжил
- Хөдөлмөрийн үйл ажиллагаа ба хүний эрх
- Нийгмийн оролцоо

2,179

Ажилтан цалин, урамшууллаа
нэмэгдүүлэн ажиллав

450+

Ажилтан албан тушаал
дэвшив



₮17.53 тэрбум

13 төрлийн
үйл ажиллагааг дэмжин
ажиллалаа

500

Шинэ ажилтан
томилогдов

Нийгмийн зээлийн багц

₮1.1 их наяд

Жендэрийн
манлай байгууллага

Гомдол
шийдвэрлэсэн хувь

100%

ОЛОН ТАЛТ БАЙДАЛ БА ТЭГШ ОРОЛЦОО

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН БОДЛОГО

ХХБ нь нийгэмд тулгарч буй тэгш бус байдал болон олон талт ялгаатай байдлыг ойлгож, жендэрийн мэдрэмжтэй банк санхүүгийн байгууллага болох зорилго тавьж, Жендэрийн эрх тэгш байдлын бодлогыг анх 2019 оны 12 сард баталж, 2021 онд Жендэрийн хороог шинэчлэн байгуулсан ба байгууллагын бүхий л түвшинд бодлогын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ХХБ нь үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний хувьд жендэрийн эрх тэгш байдлыг хангаж ажиллах зорилгын хүрээнд “Жендэрийн эрх тэгш байдлын бодлого”-ыг хэрэгжүүлж ажилладаг. Энэхүү бодлого нь НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилгын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилго, зорилтууд, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021 он), Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах байгууллага, агентлагийн жендэрийн бодлого (2016-2024)-д тус тус нийцсэн болно.

ХХБ-ны Жендэрийн хороо нь тус бодлогыг банканд хэрэгжүүлэн ажилладаг ба үүргийнхээ дагуу улирал бүр хуралдаж, банканд жендэрийн эрх тэгш байдлыг хангаж ажиллах үүднээс хүйсээр ангилсан харилцагчдын мэдээллийн сан үүсгэх, ХХБ-ны газар, нэгжүүдийн бизнесийн үйл ажиллагаа, салбар, тооцооны төвүүдийн үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэйгээр явуулах боломжийг тогтмол судлан хэлэлцэж, зохих шийдвэрийг гарган ажиллаж байна.

Нийт ажилтнуудын чадавхыг бэхжүүлэхийн тулд банкны дунд болон дээд түвшний 100 гаруй ажилтанд жендэрийн мэдрэмжтэй менежментийн талаар сургалтыг зохион байгуулснаас гадна шинэ ажилтнуудыг чадавхжуулах сургалтад “ХХБ-ны Жендэрийн эрх тэгш байдлын бодлого” хэмээх сургалтын хөтөлбөрийг нэмж жендэрийн талаарх үндсэн ойлголтуудыг тогтмол хүргэж байгаа билээ.

Жендэрийн хорооны харьяа “Gender Networking club” буюу ажилтнуудын сайн дурын клубийг үүсгэн байгуулж жендэрийн талаарх мэдлэг, мэдээллийг түгээх, ажилтнуудын оролцоо, санаачилгыг дэмжих зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна. Клуб нь улирал тутам албан бус уулзалт зохион байгуулж, олон талт ялгаатай байдал болон жендэрийн эрх тэгш байдлын талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, бусад сайн туршлагуудыг судалж, банканд хэрэгжүүлж болох шинэ ажлын санаачилгыг Жендэрийн хороонд уламжлан ажилладаг.

ХХБ нь ажлын байрны бэлгийн дарамт болон ялгаварлан гадуурхалтын эсрэг зогсдог бөгөөд энэ талаар “ХХБ-ны Ёс зүйн дүрэм”, “ХХБ-ны Шүгэл үлээх бодлого”, “ХХБ-ны Жендэрийн эрх тэгш байдлын бодлого”-уудад тус тус заан, оруулсан байдаг.

Харилцагчдын хүйсийн харьцаа




Монголын тогтвортой санхүүгийн холбоотой хамтран Санхүүгийн салбар дахь жендэрийн мэдрэмжтэй салбар хэлэлцүүлэг арга хэмжээнүүдэд идэвхтэй оролцож, 2022 оны Тогтвортой санхүүжилтийн Манлайлагч байгууллагын хувьд бид Жендэрийн мэдрэмжтэй санхүүжилтийг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллаж байна.

Нийгэмд тулгарч буй санхүүгийн хүртээмжгүй байдал болон жендэрийн тэгш бус байдлыг бууруулахыг тулд санхүүгийн хувьд уян хатан нөхцөлтэй зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлж, үйл ажиллагааг нь дэмжих замаар жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжихийн зэрэгцээ жендэрийн эрх тэгш байдлыг хангахад хувь нэмрээ оруулах зорилгоор ХХБ нь Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийг 2021 оны 10 дугаар сараас эхлэн харилцагчдадаа олгож эхэлсэн. Энэхүү зээлийн бүтээгдэхүүн нь эмэгтэй хувьцаа эзэмшигчид давуу, эмэгтэй гүйцэтгэх удирдлагатай болон эмэгтэй ажилтнууд давамгайлсан бизнес, аж ахуйн нэгжүүдэд таатай нөхцөлөөр олгож байна.

Банк нь “Хөдөлмөрийн тухай хууль”-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг ба тус хуульд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууддаа зориулан ээлжийн амралтын нэмэгдэл өдрүүд, ажлын богиносгосон цаг зэргээр дэмжлэг үзүүлж ажилладаг.

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны нийт ажилтны тоонд эзлэх хувь **0.6%** байна.



Дундаж цалингийн зөрүү
516,452 ₮



	Хүйсээр		Байршлаар		Насны бүлгээр			Нийт
	Эрэгтэй	Эмэгтэй	УБ	Орон нутаг	26-с доош	26-35	36-с дээш	
Нийт ажилтан	721	1458	1983	196	703	1028	448	2179
Шинэ ажилтан	184	316	470	30	325	155	20	500
Гэрээт ажилтан	-	19	19	-	-	-	19	19

Бид шударга ёс, олон талт байдал, тэгш боломжийн соёлыг төлөвшүүлэхийн зэрэгцээ ажилчдын сайн сайхан байдлыг дэмжиж, тогтвортой өсөлтийг хангах, зах зээлд өрсөлдөхүйц цалин, урамшууллын багцыг боловсруулан ажилладаг. Бид банкны амжилтыг хариуцлагатай авч явахын зэрэгцээ ажилтнуудаа зохих ёсоор шагнаж урамшуулахын тулд тогтолцоогоо улам боловсронгуй болгож, салбарын стандартын дагуу харьцуулж, сайжруулж байдаг.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (ХХДХ)-тэй харьцуулбал		
	Эрэгтэй	Эмэгтэй
Дундаж цалин	6.2*	4.9*
G4-5 Удирдах ажилтан болон ахлах мэргэжилтэн	11.1*	10*
G2-3 Мэргэжилтэн болон ажилтнууд	5*	4.5*
G1 Ажилтнууд	3.4*	2.4*

*дахин өндөр байна

АЖЛЫН ТАВ ТУХТАЙ НӨХЦӨЛ БА ХӨГЖИЛ

СУРГАЛТ, ХӨГЖИЛ

Тогтвортой өсөлт, хариуцлагатай банкны зарчмыг эрэлхийлэгчийн хувьд сургалт, хөгжил нь ирээдүйн боловсон хүчнийг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд банк нь тогтвортой санхүүгийн хувьсан өөрчлөгдөж буй орчныг чиглүүлэх, илүү уян хатан, хүртээмжтэй нийгэмд хувь нэмрээ оруулахад шаардлагатай мэдлэг, ур чадвар, сэтгэлгээгээр ажилтнуудаа хангахад анхааран ажиллаж байна.

ХХБ нь салбартаа манлайлагч байдгийнхаа хувьд тогтвортой хөгжил, хүний нөөцийн бодлогоор дамжуулан сургалт, хөгжлийн цогц моделийг боловсруулан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг ба мэдлэг олгох сургалт, техникийн ур чадварыг хөгжүүлэх, инновац, олон талт байдал, оролцооны соёлыг төлөвшүүлэх, хариуцлагатай хөрөнгө оруулалтын талаарх ойлголтыг нэмэгдүүлэхийг эрмэлздэг.

ХХБ нь 2022 онд 217 төрлийн 622 удаагийн сургалтыг давхардсан тоогоор 17136 ажилтныг хамруулан зохион байгуулсан байна. Энэ нь, ХХБ-ны нэг ажилтан 2022 онд дунджаар 9 сургалтад хамрагдсан гэсэн үг юм. Давхардаагүй тоогоор зохион байгуулагдсан сургалтын цагийг, ажилтны тоонд харьцуулбал нэг ажилтан жилд дунджаар 4.1 цагийн сургалтад хамрагдсан байна.

Үүнээс гадна Udemy, Melearn.mn онлайн сургалтын платформын эрхийг нэвтрүүлэн нийт ажилтнууд ашигладаг бөгөөд энэхүү платформоос ажилтан хувь хүний хөгжил, ажил мэргэжлийн мэргэшүүлэх хүссэн сургалтдаа хамрагдах боломжтой юм.




17136 ажилтан

217 төрөл

622+ удаагийн сургалт

Сургалтанд хамрагдсан ажилтнууд



- Дээд шатны удирдлагуудад
- Дунд шатны удирдлагуудад
- Нийт ажилтнуудад



Тайлант хугацаанд дотоодоос нийт 622 сургалт зохион байгуулагдсанаас 142 буюу 23 хувь нь дунд шатны удирдлагуудад зориулсан, 9 буюу 1 хувь нь дээд шатны удирдлагуудад зориулсан, үлдсэн 76 хувь нь нийт ажилтнуудыг чадваржуулах, мэдлэг мэдээлэл олгоход чиглэсэн сургалт байна.

Бид ажилтнуудынхаа хөгжилд тогтмол анхаардаг ба тэдний мэргэжлийн хөгжил, өсөлт нь бидний урт хугацааны амжилтад амин чухал хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Тогтвортой байдал, хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааг эрхэмлэх амлалтынхаа нэг хэсэг болгон бид залгамж халааг сайтар төлөвлөж, ажилчдадаа карьерын өсөлтийн өргөн боломжийг олгодог. Энэ нь авьяас чадварын тогтвортой байдлыг хангаж, тасралтгүй суралцах соёлыг төлөвшүүлж, хувь хүн болон байгууллагын шилдэг туршлагыг бий болгох чухал үйл явц юм.

2022 онд банкны ололт амжилтын тулгуур болсон үнэ цэнтэй 2179 ажилтныхаа сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, цалин хөлс, урамшууллын оновчтой системийг хэрэгжүүлэн ажиллаа. Үүнээс гадна тайлант онд банк нь 116 бүтэн цагийн ажлын байрыг шинээр бий болгосон бөгөөд 500 ажилтан шинээр ажилд томилогдсон байна. Банк нь 2021 онд ажилтнуудаа тасралтгүй хөгжүүлэх, мэргэшүүлэх Банкны алсын хараа, эрхэм зорилго, урт хугацааны зорилтуудтай уялдуулан ажлын байрны зорилго, зорилтод хүрэхэд шаардлагатай чадамжуудыг тодорхойлох “ХХБ-ны Чадамжийн толь бичиг”-ийг боловсруулан, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Ингэснээр ажилтнуудын чадамжийг хөгжүүлэх замаар бизнесийн тогтвортой өсөлтийг ханган ажиллах боломжийг бүрдүүлсэн бөгөөд банкны үнэлгээний тогтолцоог дахин загварчлан, боловсруулж Чадамжийн үнэлгээг хийж, гүйцэтгэсэн юм.

Гүйцэтгэлийн үнэлгээ: ХХБ нь ажилтнуудын гүйцэтгэлийг улирал бүр үнэлж, баталгаажуулдаг. Гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдах шалгуур нь ХХБ -нд тухайн тайлант хугацааны талаас илүү хугацаанд ажилласан байх явдал юм. 2022 онд улирал бүр нийт ажилтнуудын 85% нь ажлын гүйцэтгэлээ үнэлж, дүгнүүлсэн байна.

Карьер төлөвлөлт: Шинэ ажилтан тухайн ажлын байранд жинхлэгдсэнээс хойш өөрийн карьер төлөвлөлтийг хийж эхэлдэг бөгөөд энэ талаар хариуцсан захирал болон хүний нөөцийн мэргэжилтэнтэй тухай бүр санал солилцож, зөвлөмж зөвлөгөө авдаг. ХХБ-ны хүний нөөцийн газар нь сул орон тоонд дотоод эх үүсвэрээс эн тэргүүнд авч ажиллуулах бодлого баримталдаг тул сул орон тоог дотооддоо нээлттэй ажлын байр зарлаж, сонгон шалгаруулалтыг ил тодоор хийж томилдог. Ажилтан өөрийн урт болон дунд хугацааны карьер төлөвлөлтийг дотоод сүлжээнд бүртгэх бөгөөд Хүний нөөцийн газар (ХНГ)-с ажилтны төлөвлөлтийн дагуу сонгон шалгаруулалтуудад хамруулж ажилладаг. Тайлант хугацаанд нийт 457 ажилтан карьерын хэвтээ болон босоо шилжилт хөдөлгөөн хийсэн (4 ажилтан тутмын 1) бөгөөд үүний 67% нь эмэгтэй ажилтнууд байна.



2,179

Ажилтан цалин, урамшууллаа нэмэгдүүлэн ажиллав



500

Шинэ ажилтан томилогдов



450+

Ажилтан албан тушаал дэвшив

Банк нь хүүхэд асрах чөлөө авах боломжтой бөгөөд хүсэлт гаргасан бүхий л ажилтанд холбогдох чөлөөг олгодог. Тайлант хугацаанд 124 ажилтан хүүхэд асрах чөлөө авсан бөгөөд ингэснээр банкны хэмжээнд нийт 137 ажилтан хүүхэд асрах чөлөөтэй байгаа юм. Мөн тус онд 78 ажилтан хүүхэд асрах чөлөөнөөс ирж, эргэн ажилдаа томилогдсон байна. Ажилдаа эргэж орсон ажилтнуудын тогтвортой байдлын хувь 100% буюу 2022 онд эргэж орсон 78 ажилтан бүгд одоог хүртэл ажиллаж байна.

Банк нь ажилтнууддаа дараах хангамжийг олгодог.

- Нийгмийн даатгал;
- Эрүүл мэндийн даатгал;
- Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудад хуулийн дагуу олгох даатгал шимтгэлийн хөнгөлөлт болон ээлжийн амралтын илүү өдрүүд;
- Хүүхэд асрах чөлөө (Жирэмсний болон амаржсаны амралт 120 хоног + хүүхдээ 3 нас хүртэл асрах урт хугацааны чөлөө);
- Шинэхэн аав болсон ажилтанд цалинтай 10 өдрийн чөлөө;
- Ажилтан хуримаа хийж буй тохиолдолд 1 өдрийн цалинтай чөлөө, мөнгөн тэтгэмж;
- Ажилтны ар гэрт гачигдал, харамсалтай үйл явдал тохиолдсон бол 5 өдрийн цалинтай чөлөө, мөнгөн тэтгэмж;
- Ажилтан сар бүр 4 хүртэлх цагийн цалинтай чөлөө авах эрх;
- Ажилтан тэтгэвэрт гарах үед ажилласан жилээс хамааруулан мөнгөн тэтгэмж;
- Ажилдаа амжилт гарган, хамт олноо манлайлан өндөр гүйцэтгэлтэй ажилласан ажилтнуудыг улирал бүр аялалд явуулах;
- Гүйцэтгэлээс шалтгаалан бонус, урамшуулалт цалин;
- Ажлын онцлогоос шалтгаалан өдөр бүр эсвэл 7 хоног бүрийн 5 дахь өдөр business casual хувцаслалт;
- Харилцагчдад шууд үйлчилгээ үзүүлэх ажилтнуудын баримтлах харилцагчийн үйлчилгээний стандартуудыг шинэчлэн сайжруулж батлуулснаар ажилтан зуны улиралд ч тав тухтай ажиллах боломжтой болсон.
- Банкаас тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан бэлэг өгөх, утасны ярианы эрх олгох;
- Банканд үйл ажиллагаа явуулж буй Хувь хүний хөгжлийн клуб, Good Readers номын клуб, Hiking клуб, English speaking клуб зэрэг клубүүдэд гишүүнээр элсэж, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах, түүнд оролцох;
- Ажилтан мэргэшсэн эрх, олон улсын шалгалтад амжилттай хамрагдсан тохиолдолд \$1,000 хүртэлх буцаан олголт;
- Банктай хамтын ажиллагаатай байгууллагуудад хөнгөлөлттэй нөхцөлөөс худалдан авалт хийх эрх;
- Ажлын онцлогоос хамааран no-desk буюу хаанаас ч ажиллах боломжтой уян хатан нөхцөлөөр ажиллах боломж гэх мэт.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНД

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, стандартын дагуу банкны ажилтнуудыг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлөөр хангах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг банкны хэмжээнд төлөвшүүлэх, холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар банкны барилга байгууламжийн ашиглалтын журмын 4-р бүлэгт тусгасан бөгөөд үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Ажилтнуудын хувьд шаардлагатай ажлын байр тус бүрээр хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажилтнууддаа танилцуулан ажилладаг. Үүнд:

- Жолооч нарын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
- Үйлчилгээний ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
- Цахилгааны инженерийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
- Сантехникчийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
- Мужааны хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
- Оффисын ажилтны хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа



2022 онд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА) чиглэлээр дотоод 37 цагийн сургалт, мэргэжлийн байгууллагын 32 цагийн сургалт, нийт 69 цагийн сургалт зохион байгуулагдсан байна.

Ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор МУ-ын хэмжээнд Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, оношилгоо шинжилгээ”-нд нийт ажилтнуудыг идэвхтэй хамруулах байдлаар зохион байгуулалтыг хийн ажилласан.

ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ХҮНИЙ ЭРХ

Манай банкны хөдөлмөрийн үйл ажиллагаа нь ажилтнуудын сайн сайхан байдал, эрх ашиг, хөгжлийг нэн тэргүүнд тавьдаг. Бид ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангах, гүйцэтгэлийг урамшуулах, өсөх боломжийг санал болгон, хүртээмжтэй, аюулгүй, дэмжлэг үзүүлэх ажлын орчныг хадгалахыг хичээдэг. Мөн бид хамтын ажиллагаандаа ёс суртахууныг эрхэмлэн ажиллаж байна.



Банк нь ажил олгогч болон ажилтны хоорондын хөдөлмөрийн харилцаатай холбоотой үүссэн маргаан, асуудлыг шударга, тэнцвэртэй шийдвэрлэж ажиллах зорилгоор “Хөдөлмөрийн маргаан таслах комисс”-ыг байгуулсан. Хөдөлмөрийн маргаан таслах комисс нь ажил олгогчийн төлөөлөл болон ажилтнуудын төлөөллөөс бүрдэж байна.



ХХБ нь албадан хөдөлмөр эрхлэлтийн эсрэг зогсдог бөгөөд тийм тохиолдол гарч байгаагүй болно. Банк нь гэрээт болон үндсэн бүхий л түвшний ажилтантай хөдөлмөрийн харилцааг эхлүүлэхээс өмнө хөдөлмөрийн нөхцөлийг харилцан тохиролцож, албан ёсны гэрээг цаасаар байгуулан баталгаажуулж ажилладаг.


Банкны худалдан авалтын үйл ажиллагаанд:

- “Худалдаа, хөгжлийн банканд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны заавар”-ын 4.8 заалтад нийлүүлэгчид тавигдах шаардлагыг тусгасан байдаг. Үүнд:
4.8.5 заалтад Монгол улсын хууль, журам аливаа стандартаар хориглосон үйл ажиллагаа эрхэлдэггүй байх;
4.8.6 заалтад Нийгэм болон байгаль орчинд хор хөнөөл бүхий ажил үйлчилгээ эрхэлдэггүй байх;
- Банк худалдан авалтын үйл ажиллагаанд нийлүүлэгч байгууллага сонгохдоо албадан хөдөлмөр эрхэлдэг эсэхийг харгалзан үзэж шийдвэр гаргах зарчим баримтлан ажилладаг.

НИЙГМИЙН ОРОЛЦОО

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН САНХҮҮЖИЛТ

2022 оны байдлаар ХХБ-ны нийгмийн шинж чанартай зээлийн хэмжээ 1.1 их наяд төгрөг буюу банкны нийт зээлийн багцын 24%-ийг эзэлж байна. Үүнээс ХХБ-ны нийгмийн шинж чанартай зээлийн ангиллын дагуу Дэд бүтэц; Орлогод нийцсэн орон сууц; Нийгэм, эдийн засгийн дэвшил, чадравхжуулалтын чиглэлээрх зээлийн үлдэгдэл буюу "Нийгмийн хөгжлийн санхүүжилт" нийт 617.2 тэрбум төгрөг байна.



ЖИЖИГ, ДУНД БИЗНЕСҮҮДИЙГ ДЭМЖИХ НЬ

ХХБ-ны Жижиг, дунд бизнесийн банкны газар нь Жижиг, дунд бизнес (ЖДБ) эрхлэгчид болон харилцагчдаа бизнесээ тогтвортой явуулахад нь дэмжих болон санхүүжилтийн эрэлт хэрэгцээг нь хангах зорилготой ажилладаг. Энэ хүрээнд ЖДБ эрхлэгчдийнхээ банкнаас санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор МУ-ын засгийн газар, Азийн хөгжлийн банк, Жайка, Олон улсын хөрөнгө оруулалтын банк болон Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны банкуудтай хамтран бизнесийн зээл болон төсөл хөтөлбөрийн зээлүүдийг олгосон байна.



2022.12.31-ний өдрийн байдлаар Жижиг, дунд бизнесүүдэд олгосон дараах зээлүүдийн нийт үлдэгдэл **422,590.72 сая** төгрөг байна. Үүнд:


- Ажлын байр дэмжих зээл
- Репо зээл
- Жайка төслийн зээл
- ЗБДС зээл
- ЖДҮ байгаль орчныг хамгаалах төслийн зээл
- Эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан зээл
- Бизнесийн ногоон зээл
- Бизнесийн зээл
- ЖДБ эрхлэгчдэд олгосон бусад зээл

ЭМЭГТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ЗЭЭЛ

Эмэгтэй хувьцаа эзэмшигчид давамгайлсан, эмэгтэй гүйцэтгэх удирдлагатай болон эмэгтэй ажилтнууд давамгайлсан бизнес, аж ахуйн нэгжүүдэд таатай нөхцөл бүхий санхүүжилтийг олгох замаар жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжихийн зэрэгцээ жендэрийн эрх тэгш байдлыг хангахад хувь нэмрээ оруулах зорилгоор ХХБ нь Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийг 2021 оны 10 дугаар сараас эхлэн харилцагчдадаа олгож эхэлсэн. 2022 оны 4-р улирлын байдлаар ХХБ нийтдээ 17.53 тэрбум төгрөгийн эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийг олгож эдийн засгийн 9 салбарын үйл ажиллагаанд шууд хувь нэмрээ оруулсан байна.



Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийн ангилал
/салбараар/



САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

“ХУРИМТЛАЛТАЙ МОНГОЛ” ХӨТӨЛБӨР

ХХБ нь харилцагч нартаа санхүүгийн боловсролыг түгээх, хуримтлалыг зуршил болгох, хуримтлалтай Монгол иргэдийг бий болгох зорилгоор тус хөтөлбөрийг санаачлан, 2021 оноос хойш хэрэгжүүлж байгаа бөгөөд уг хөтөлбөрийн дүнд 500'000 харилцагчдыг оролцуулсан бөгөөд тэдгээрийн хугацаатай хадгаламжийн дүн 4%-иар өссөн байна.



ХХБ нь 2022 онд Монголын банкны холбооноос Монгол банк, Цагдаагийн ерөнхий газартай хамтран зохион байгуулсан цахим залилах төрлийн гэмт хэргийн эсрэг олон нийтэд мэдлэг олгох, нөлөөллийн “UNSEND - Бүү шилжүүл” аянд оролцож, нийгмийг соён гэгээрүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг болон санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, цахим залилан, санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллав.

Мөн бид 2022 онд сар бүр Цахим луйвар, залилантай холбоотой эрсдэлээс харилцагчийн мөнгөн хөрөнгийг хамгаалах чиглэлээр банкны харилцагч нарт “Хувь хүний мэдээллийн нууцлал гэж юу вэ?”, “Цахим орчин ба хүний хувийн нууцлалтай мэдээлэл”, “Банк харилцагчийнхаа мэдээллийг хэрхэн хамгаалдаг вэ?”, “Фишинг халдлагаас өөрийгөө хэрхэн хамгаалах вэ?”, “Баталгаат бус программ хангамж, аппликейшн ашиглах сөрөг үр дагавраас сэргийлэх”, “Цахим орчинд ашиглах хандалтын төхөөрөмжийн аюулгүй байдал”, “Цахим луйвар /онлайн худалдаа/ болон төлбөрийн картын аюулгүй байдал”, “Давхар танин баталгаажуулалт”, “Ухаалаг төхөөрөмжийн аюулгүй хэрэглээ, аюулгүй байдал” зэрэг сэдвүүдийн хүрээнд сэрэмжлүүлэг, зөвлөмж мэдээллийг постер, цахим хэлбэрээр бэлтгэн банкны социал сувгаар нийт харилцагч нартаа хүргэн учирч болзошгүй цахим эрсдэлээс сэргийлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулан ажилласан байна.

ХАРИЛЦАГЧ ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ



127,426 харилцагч
6 арга хэмжээ
62 өдөрлөг
9 аян

ХХБ нь 2022 онд иргэдийн санхүүгийн боловсролыг дэмжих, банкны бүтээгдэхүүн үйлчилгээг таниулах зорилгоор 9 аян, хөтөлбөр, 6 арга хэмжээ, 62 байгууллагад өдөрлөг зохион байгуулж ажиллаа. Эдгээр үйл ажиллагаанд давхардсан тоогоор нийт 127,426 харилцагч хамрагдаж бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээллийг авсан байна. Харилцагчдадаа эрсдэлээс хамгаалах зөвлөмжийг тогтмол хүргүүлж, нийт 6 тэрбум төгрөгийн эрсдэлээс харилцагчдаа хамгааллаа.




ХУРИМТЛАЛТАЙ МОНГОЛ



БОРЛУУЛАЛТЫН МАРАФОН



ДЭЛХИЙН ХУРИМТЛАЛЫН ӨДӨР



HAPPY BRANCH - HAPPY STAFF



HAPPY 23 DAYS



HAPPY STAFF - HAPPY TEAM



HAPPY LOYALTY - ВИЗАТАЙ ХАМТ КАТАРТ



VISA CASHBACK



UNIONPAY CASHBACK

ХАРИЛЦАГЧ БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНУУДЫН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

Тайлант хугацаанд Дархан, Эрдэнэт хотуудын бизнес эрхлэгчдэд ХХБ-ны төслийн зээлийн талаар мэдлэг олгох, танилцуулах сургалтыг зохион байгуулсан, мөн Зээлийн батлан даалтын сангаас зохион байгуулсан арга хэмжээнд ХХБ-аас оролцож танилцуулга хийсэн зэргээр төслийн зээлийн мэдлэг, мэдээллийг нийт 185 хүнд өгсөн байна.

Бид санхүүгийн үйлчилгээг олон нийтэд таниулах зорилготой контентууд бэлтгэж түгээдэг бөгөөд 2022 онд найдвартай санхүүгийн үйлчилгээг ашиглан эрсдэлээ бууруулж болохыг таниулах зорилгоор “Худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүн”-ний видео танилцуулгыг бэлтгэн TDB вэб сайт, Bloomberg TV болон социал сувгаар дамжуулан олон нийтэд танилцууллаа.

Мөн харилцагч байгууллагын ажилтнуудад санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээгээ таниулах, сургалт, өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулж байна. 2022 онд дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллалаа. Үүнд:

- Bloomberg TV-ээс зохион байгуулдаг “Woman Summit” арга хэмжээнд 180 эмэгтэй бизнес эрхлэгч харилцагч нараа урьж, санхүүгийн шинэ мэдээ, мэдээлэл солилцох боломжийг олголоо.
- Харилцагч байгууллагын хүсэлтийн дагуу “Худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүн”, тэр дундаа Аккредитив, банкны баталгааны талаар 10 гаруй байгууллагын 100 гаруй ажилтанд сургалт зохион байгууллаа.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

2022 оны туршид ХХБ нь нийгмийн хариуцлагын хүрээнд **13** төрлийн ажлыг зохион байгуулж, ивээн тэтгэж хамтран ажиллалаа.




ХЯЗГААРГҮЙ МӨРӨӨДӨЛ

Ерөнхий боловсролын 133, 146 дугаар сургууль болон Орхон аймгийн 5 дугаар сургуулийн номын санг тохижуулж, номын нөөцийг арвижууллаа. Мөн АШУУИС, МУИС, Монгол Улсын Консерваторийн номын санг тохижуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр дэмжив.



ДҮДҮ ХҮҮХДИЙН МУЗЕЙ

Дүдү музейг аврах аянд нэгдэж 250 тасалбар худалдан авлаа.



ШАМБАЛА ИНЖЕНЕРИНГ КАМПУС ХХК

Шамбала инженеринг кампус ХХК-аас санаачилсан "Go Zero" буюу уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг бүх нийтийн оролцоог уриалах арга хэмжээнд хамтран зохион байгуулагчаар оролцлоо.



ШАМБАЛА 2056 – МОД ТАРИХ АЯН

Шамбала 2056 - Шамбала инженеринг кампус ХХК-ын "Шамбала 2056 - Мод тарих аян"-д ХХБ-ны ажилтнууд нэгдэн Дорноговь аймгийн Эрдэнэ сумд байгуулагдаж буй Урлаг Технологийн Эзэнт Гүрэн лэнд арт-д мод худалдан авч, дэмжин ажиллаа.



HAPPY ART - HAPPY FAMILY

"HAPPY ART - HAPPY FAMILY" гар зургийн уралдааныг хүүхэд, гэр бүлийн дунд зохион байгуулж, оролцсон бүтээлүүдийг Улаанбаатар хотын автобусны буудлуудад байршуулах, Happy Show арга хэмжээний үеэр танилцуулах, дэвшилтэт технологийг ашиглан VIRTUAL орчинд үзэсгэлэн гаргах зэргээр олон нийтэд танилцууллаа.



BLOOMBERG MEDIA SCREEN СУРТАЛЧИЛГАА

Дэлхийн зүрхний өдөр, Дэлхийн хүүхдийн өдрүүдийг хамтран сурталчиллаа.



ХУРИМТЛАЛТАЙ МОНГОЛ

Маамуу хүүхдийн хадгаламжийн урамшуулалт аяны хүрээнд нийт 42 хүүхдийг азтанаар тодруулж мөнгөн хадгаламж, нэг хүүхдийг турк улсаар аялах эрхээр урамшууллаа. Мөн хүүхдийн хадгаламжийн урамшуулал болгож 20,000 хүүхдэд TomYo аппликэйшний 5 гадаад хэлний бүх түвшний хичээлийг үзэх 1 сарын эрх бэлэглэхээр боллоо.



“DIAMOND” СПОНСОР

Улс хоорондын бизнесийн харилцааг сайжруулах зорилгоор Австралийн Худалдаа аж үйлдвэрийн танхим, АНУ-ын Худалдааны танхим, Монголын бизнесийн зөвлөл зэрэг байгууллагуудын жил бүр зохион байгуулдаг гала арга хэмжээний “Diamond” спонсороор тус тус ажиллалаа.



“GREENIFY” ХАКАТОН

НҮБ-ын Залуу төлөөлөгч хөтөлбөрийн “Гоё хүмүүстэй дэлхий” төслийн багаас зохион байгуулсан “Greenify” хакатон арга хэмжээг дэмжин ажиллалаа.

ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

ХАРИЛЦАГЧИЙН САНАЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ


Харилцагчийн үйлчилгээний газар нь банкны талаарх санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл ажиллагааг “ХХБ-ны харилцагчид үйлчлэх үйлчилгээний бодлого” болон “ХХБ-ны харилцагчийн эрх ашгийг хамгаалах журам”-аар зохицуулдаг ба харилцагчийн санал, хүсэлтийг банкны боломжит бүх сувгуудаар хүлээн авахад тогтмол анхаарч, банкны бүх шатанд харилцагчийн мэдээллийн нууцлалыг дээд зэргээр хангахаас гадна аливаа харилцагчийн санал хүсэлт, гомдлыг банкны газар, хэлтэс, нэгжүүдтэй хамтран түргэн шуурхай шийдвэрлэх, уг гомдлыг дахин гарахгүй байхад анхаарч ажилладаг. “ХХБ-ны харилцагчийн эрх ашгийг хамгаалах журам”-ын дагуу хүлээн авсан харилцагчийн санал хүсэлт, гомдолд хяналт тавих, уг санал, хүсэлт, гомдолд холбогдох газар, хэлтэс, банкны нэгжүүдэд программаар дамжуулан түргэн шуурхай шийдвэрлүүлэх, дахин гарахаас урьдчилан сэргийлэхэд нягт хамтран ажилладаг.

Харилцагчийн бүтээгдэхүүн үйлчилгээний үнэлгээ болон санал, гомдлыг хүлээн авах QR кодыг банкны нэгжүүдэд байршуулснаар шуурхай, хялбар аргаар санал хүсэлтээ илэрхийлэх боломжтой болоод байна. Жил бүрийн 3 сарын 15-ны өдрийг дэлхий даяар олон улсын хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах өдөр гэж зарласантай холбоотой харилцагчийн санал хүсэлт, гомдлыг хэрхэн шийдвэрлэх тухай олон нийтэд мэдээллэж ажилладаг. Дуудлагын төвд ирж буй харилцагчийн санал хүсэлт,

гомдлыг цаг алдалгүй хүлээн авч, шийдвэрлэн, харилцагчдын давтан дуудлага болон, гомдлыг бууруулах, SLA дуудлагын чанарыг ямагт өндөр байлгахыг зорин ажилладаг.

Тайлангийн хугацаанд нийт 3065 санал хүсэлт, 1986 гомдол, 250 талархал банканд бүртгэгдсэн бөгөөд харилцагчдын ирүүлсэн **5,380** харилцагчийн санал хүсэлт, гомдлыг хамгийн бага хугацаанд 100%-н гүйцэтгэлтэй шийдвэрлэж ажилласан.

2021 онтой харьцуулахад:



ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЙЖРУУЛАЛТ

Банкны стратеги, зорилго, зорилтын хүрээнд нийт ажилтнууд бүх түвшний үйл ажиллагаанд мөрдөн ажиллах Харилцагчид үйлчлэх үйлчилгээний бодлого, журмыг шинэчлэн батлуулсан ба уг бодлогын хэрэгжилтэд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг баримтлах талаар тусгасан ба харилцагчид жендэрийн мэдрэмжтэй үйлчилгээг үзүүлж, эрх тэгш оролцоог хангахад чиглэх талаар тусгаснаараа онцлогтой болсон.



Харилцагчийн хүлээлтээс давсан бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэж байгаа эсэхэд үйлчилгээний чанар болон харилцагчийн сэтгэл ханамжийн түвшинг тогтмол хэмжиж, үзүүлэлтийг нэмэгдүүлэхэд анхаарч, харилцагчийн үйлчилгээ авч буй суваг бүрээрх харилцагчийн сэтгэл ханамжийг **CSAT** болон **NPS** олон улсын аргачлалын дагуу тодорхойлох судалгааны хөгжүүлэлтүүдийг хийж нэвтрүүлсэн.

Харилцагчид хүрч буй боломжит суваг бүрээрх үйлчилгээг түргэн, шуурхай чирэгдэлгүй, хүртээмжтэй хүргэх, тасралтгүй байлгахад анхаарч, Харилцагч төвтэй банк болох зорилгод нийцүүлсэн олон улсын стандартуудыг судалж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсээр байна.

Салбарын дугаар дуудагч системийг шинэчлэх замаар харилцагчид үйлчилгээ үзүүлэх стандарт үзүүлэлтүүдийг хэмжих, хянах, дата анализ хийх болон сэтгэл ханамжийн судалгааг харилцагч бүрээр тодорхойлох боломжийг бий болгосон.

Банкны аль ч салбарт үйлчлүүлсэн мэргэжлийн чадварлаг үйлчилгээг харилцагчдадаа үзүүлж чадсан эсэхийг салбараар үйлчлүүлсэн харилцагчдаас мессеж болон утсан судалгааны аргаар тогтмол хүлээн авч, банкны харилцагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхээр зорьж ажиллаж байна.

Харилцагчийн өгөгдлийн чанарыг үзүүлэлт бүрээр үнэлэн, тасралтгүй сайжруулах арга, хэрэгслийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн бөгөөд харилцагчийн мэдээлэл шинэчлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад **18%**-иар өссөн үзүүлэлттэй байна. Хувийн хэргийн цахим санд нийт цаасан хувийн хэргийг цахимжуулан төвлөрүүлж, Харилцагчид үйлчлэх үйлчилгээний бодлогод нийцүүлэн байгаль орчинд ээлтэй, цаасгүй, цахим шийдлээр харилцагчид хүргэсэн байна.



Дуудлагын төвийн үйлчилгээг сайжруулахаар олон улсын **Genesys** системийг банкны суурь системтэй амжилттай холбосноор харилцагч ажилтантай холбогдохгүйгээр IVR дээрээс үйлчилгээ авах боломжийг эхлүүлсэн. Мөн социал хэрэглээ бүхий сувгуудыг ашиглаж олон харилцагч руу нэг дор холбогдох болон олон тооны харилцагчтай богино хугацаанд холбогдож мэдээлэл хүргэх боломжтой болсон.

Бид банкны харилцагчдадаа бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээлэл болон үйлчилгээг хүргэхдээ банкны боломжит сувгууд буюу мессеж, имэйл, мэдэгдлийн үйлчилгээ болон банкны ажилтнаар дамжуулан тогтмол түргэн шуурхай мэдээллээ хүргэхэд анхаарч, харилцагчийн санал, хүсэлтийг бүхий л сувгуудаар нээлттэй хүлээн авч, эргэх холбоотой шуурхай шийдвэрлэхэд стандарт хугацааг баримтлан ажилладаг.

ЗАСАГЛАЛ

БҮЛГИЙН АГУУЛГА

- Компанийн засаглал
- Ёс зүй ба комплайнс
- Мэдээллийн аюулгүй байдал, нууцлал

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Тогтвортой ажиллахад компанийн үр дүнтэй засаглал хамгийн чухал. Энэ нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн асуудлуудыг шийдвэр гаргах үйл явц, байгууллагын урт хугацааны стратегид тусгах боломжийг олгодог. Оновчтой засаглалын тогтолцоо нь ил тод байдал, хариуцлагатай байдал, ёс зүйтэй зан төлөвийг дэмжиж, тогтвортой үйл ажиллагааны бат бөх суурийг бүрдүүлдэг.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ХХБ-ны ТУЗ нь байгууллагын бүхий л шатанд ил тод, үнэнч шударга байдлыг чухалчлан, нээлттэй засаглалыг бий болгохын зэрэгцээ ямар ч нөхцөлд тохирсон алсын хараа, стратеги бүхий бодлогоор банкны үйл ажиллагааг чиглүүлж, дэмжин ажилладаг.



РАНДОЛЬФ КОППА
ТУЗ-ийн дарга



Д.ЭРДЭНЭБИЛЭГ
ТУЗ-ийн гишүүн



Д.ХҮРЭЛБААТАР
ТУЗ-ийн гишүүн



Д.ЯНЖМАА
ТУЗ-ийн гишүүн



Ж.БОЛОРМАА
ТУЗ-ийн хараат бус гишүүн



Ж.ДЭЛГЭРСАЙХАН
ТУЗ-ийн хараат бус гишүүн



Н.НЯМСҮРЭН
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

УДИРДЛАГЫН БАГ

ХХБ-ны удирдлагын баг нь банк, санхүүгийн чадварлаг менежерүүдээс бүрддэг ба компанийн засаглалын зохистой бүтэц, олон жилийн туршлага нь удирдлагын багийн амжилттай ажиллах суурь нь болдог. Мөн банкны урт удаан хугацааны ашигт ажиллагааг хангах, улмаар хувь нийлүүлэгчдийн үнэ цэнийг өсгөх боломжийг олгодог ХХБ-ны удирдлагын баг нь банк, санхүүгийн чадварлаг менежерүүдээс бүрддэг ба компанийн засаглалын зохистой бүтэц, олон жилийн туршлага нь удирдлагын багийн амжилттай ажиллах суурь нь болдог. Мөн банкны урт удаан хугацааны ашигт ажиллагааг хангах, улмаар хувь нийлүүлэгчдийн үнэ цэнийг өсгөх боломжийг олгодог.

АЖИЛТНУУД

ХХБ-ны амжилтын үндэс нь эрч хүчтэй, чадварлаг ажилтнууд бөгөөд тэднийг шударгаар урамшуулах, дэмжих, албан тушаал дэвшүүлэх хөгжлийн тогтолцоог сайжруулснаар харилцагчдадаа банкны шилдэг үйлчилгээг үзүүлж чаддаг.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ЗОРИЛГО

ХХБ-ны амжилтын үндэс нь эрч хүчтэй, чадварлаг ажилтнууд бөгөөд тэднийг шударгаар урамшуулах, дэмжих, албан тушаал дэвшүүлэх хөгжлийн тогтолцоог сайжруулснаар харилцагчдадаа банкны шилдэг үйлчилгээг үзүүлж чаддаг.

ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


Банк нь өөрийн зохицуулагч байгууллага буюу Монголбанкны зохистой засаглалын журмын дагуу засаглалын бодлого, журмуудыг батлан, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж ирсэн. Тухайлбал банк нь “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ыг батлан үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж байна.

Тус журмаар Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, ТУЗ-ийн дарга, гишүүдэд тавих шалгуур, гишүүнийг томилох, сонгох, бүрэн эрх, үүрэг, хурал явуулах дэг зэрэг Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулдаг. Үүнээс гадна, ТУЗ-ийн дэргэдэх Аудит, Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх, Эрсдэлийн удирдлагын хороод ТУЗ-ийн дэргэдэх Ажлын алба нь тус тусын холбогдох үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журамтай байдаг ба банк нь эдгээр бодлого журмуудыг тогтмол сайжруулан шинэчилж байдгаараа онцлог бөгөөд компанийн хэмжээнд зохистой засаглалыг бий болгоход чухал нөлөөтэй юм.

ХХБ нь МонголБанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн А-143 тоот тушаалаар батлагдсан “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам”-ын дагуу засаглалын дотоод үнэлгээний тайланг жил бүр хүргүүлж, дүгнүүлдэг бөгөөд 2022 онд уг журмын үнэлэх загварын дагуу “Сайн” үнэлгээ авсан.

ЦАЛИН УРАМШУУЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

Хороо нь Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хяналт, удирдлагын үүргээ үр дүнтэй, банкинд ашигтай гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй болно.



АУДИТЫН ХОРОО


Аудитын хороо нь Хувь нийлүүлэгчид болон ТУЗ-д банкны дотоод аудит, хөндлөнгийн аудит, дотоод хяналтын систем, эрсдэлийн удирдлага, санхүүгийн тайлан, ёс зүйн дүрэм, хууль журмын хэрэгжилтийн байдалд үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах, аудитын үйл ажиллагааны үр дүнг Хувь нийлүүлэгчид болон ТУЗ-д мэдээлэх, банкны удирдлага, зохион байгуулалтын бүх түвшинд байгууллагын сайн засаглалын тогтолцоог бэхжүүлэх үүрэгтэй.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРОО

Эрсдэлийн удирдлагын хороо нь ХХБ-ны эрсдэлийн удирдлагын бодлого, эрсдэлийн чиг хандлага, эрсдэл даах чадамжийг тодорхойлон ажиллах, эрсдэлийн үндсэн төрлүүд болох зээлийн эрсдэл даах чадамжийг тодорхойлон ажиллах, эрсдэлийн үндсэн төрлүүд болох зээлийн эрсдэл, зах зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл болон үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд эрсдэлийг тогтоох, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг хянах, бууруулах, тэдгээрийг удирдахад чиглэгдсэн оновчтой арга хэмжээг авах ажлыг зохион байгуулж, чиглүүлэх, нэгдсэн удирдлагаар ханган ажиллах эрх, үүрэгтэй.

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэгт Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна гэж заасан бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөл нь тус хуулийн 76 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг эдэлнэ. Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь 2022 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 6 гишүүнтэй байсан бөгөөд үүний 2 нь хараат бус гишүүн байна.

ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, чөлөөлөх, ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний асуудлыг хэлэлцэн, ТУЗ-ийн хуралд танилцуулахаар тус хорооны журамд заасан байдаг. ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулахдаа хуулийн ерөнхий шаардлага буюу “Банкны тухай хууль”-ийн 32.1.1-32.1.7-р заалт, хараат бус гишүүнд тавигдах хуулийн нэмэлт шаардлага буюу “Банкны тухай хууль”-ийн 33.3.1-33.3.8-р заалт, “Компанийн тухай хууль”-ийн 79.1.1-79.1.5 заалтуудыг баримтлахаас гадна олон улсын сайн туршлагын дагуу удирдлагад таарах, зүй зохистой хүн эсэхийг дараах 5 шалгуураар үнэлдэг. Үүнд:



1. Ажлын туршлага
2. Нэр хүнд
3. Ашиг сонирхлын зөрчил ба үзэл бодлын бие даасан байдал
4. Time commitment буюу үүргээ биелүүлэх цаг хугацаа
5. Хамт олны нийцэл

Түүнчлэн ТУЗ-ийн бүрэлдэхүүн, давуу тал, ур чадвар ба чадамж нь Банканд одоо буй болон ирээдүйд тулгарах дунд хугацааны стратегийн зорилт, сорилт, эрсдэлтэй аль болох зохицсон байх нь зүйтэй гэж үздэг.

УДИРДЛАГЫН БАГ



О.ОРХОН
Гүйцэтгэх захирал



RAHN WOOD
Ерөнхийлөгч



STEPHANE LAMOUREUX
Гүйцэтгэх захирлын
тэргүүн орлогч



О.БАНЗРАГЧ
Гүйцэтгэх захирлын
тэргүүн орлогч



А.ЭНХМЭНД
Гүйцэтгэх захирлын
тэргүүн орлогч



Ч.СОЛОНГО
Гүйцэтгэх захирлын
орлогч



П.МӨНХНАСТ
Гүйцэтгэх захирлын
орлогч



Ц.ГАНБАЯР
Гүйцэтгэх захирлын
орлогч



Л.ГАНТӨМӨР
Гүйцэтгэх захирлын
орлогч



С.БААТАР
Гүйцэтгэх захирлын
орлогч



Г.ГАНЦЭЦЭГ
Гүйцэтгэх захирлын
орлогч

ЁС ЗҮЙ БА КОМПЛАЙНС

КОМПЛАЙНСЫН БОДЛОГО

Банк нь “Худалдаа, хөгжлийн банкны Комплайнсын бодлого”-ыг 2021 онд шинэчлэн найруулж, ТУЗ-өөрөө батлуулсан. “Худалдаа, хөгжлийн банкны Комплайнсын үйл ажиллагааны журам”-ыг 2022 онд шинэчлэн найруулж мөн ТУЗ-өөр батлуулсан. Эдгээр бодлого журмаар банкны комплайнсын үүргийг Төрийн эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах; Гадаад, дотоодын банк санхүүгийн байгууллагатай харилцах; Эрх зүйн нийцлийг хангаж ажиллах; Банкны дотоод үйл ажиллагаанд Комплайнсыг хэрэгжүүлэх; Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай үйл ажиллагааг хэрэгжүүлэх гэсэн үндсэн чиглэл, хүрээг хамруулан банк комплайнсыг хэрэгжүүлэхээр тусгасан.

Мөн түүнчлэн, энэхүү бодлого, журмыг хэрэгжүүлэхдээ Хууль тогтоомжийн нийцлийн зарчим; Шударга байх зарчим; Банкны ажил хэргийн нэр хүнд, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах зарчим; Харилцагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх зарчим; Ил тод, тодорхой байх зарчим; Аливаа шийдвэр нь баталгаат эх сурвалж, судалгаанд үндэслэсэн байх зарчим; Хариуцлага хүлээх зарчим; Инновацлаг байх зарчим; Бие даасан, хараат бус байх зарчим зэргийг хэрэгжүүлэн ажиллахаар сайжруулан шинэчилсэн.

Ингэснээр банк нь комплайнсын үйл ажиллагааны цар хүрээг Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээс тэлж, илүү олон улсын хийгээд тогтвортой хөгжил рүү чиглүүлэх боломжийг бүрдүүлсэн. Дээрх байдлаар Комплайнсын бодлого болон журмыг шинээр боловсруулж, агуулгыг тэлэхдээ олон улсын ISO 37301: Compliance management systems стандартыг баримтлан ажилласан бөгөөд энэ нь тэр чигтээ банкны үйл ажиллагааг урт хугацаанд, зөв - тогтвортой явуулахад чиглэсэн, олон улсын шаардлагуудыг хамарсан болно. Ингэснээр банкны газар, хэлтэс зэрэг бүх нэгжүүд нь комплайнсын хэрэгжүүлэгч салшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг болж, банк нийтээрээ complied-нийцсэн байхад үйл ажиллагаагаа чиглүүлж байна.



ШИНЭ АЖИЛТНЫ СУРГАЛТ

Шинээр ажилд орж буй нийт **349** ажилтанд 19 удаагийн давтамжтайгаар орсон байна.



БАТАТГАХ СУРГАЛТ

Нийт 3 удаагийн давтамжтайгаар **194** ажилтанд Бататгах сургалтыг орсон байна.



ТУСГАЙЛСАН СУРГАЛТ

Нийт **2** удаагийн давтамжтайгаар дараах газар, хэлтсүүдэд тусгайлсан сургалт орсон. Үүнд:

- Олон улсын банкны газар
- Худалдааны санхүүжилт, бүртгэлийн хэлтэс

Банк нь 2021 онд “Худалдаа, хөгжлийн банкны Комплайнсын бодлого”, 2022 онд “Худалдаа, хөгжлийн банкны Комплайнсын үйл ажиллагааны журам”-ыг тус тус ISO37301 стандартад нийцүүлэн шинэчлэн найруулж, банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан ба банкны өдөр тутмын үйл ажиллагаанд баримтлан ажиллаж байна.

Дээрх комплайнсын бодлого, журам нь комплайнсын бодлого, чиг үүргийг оновчтой зөв зохион байгуулах, банкны газар нэгжүүдийн комплайнсын чиг үүргийг тодорхойлж, банкны бүх шатанд хэрэгжүүлэн ажиллах, эрсдэлээс урьдчилан сэргийлж, нийцлийг хангаж ажиллах зорилготой юм.

Комплайнсын бодлого, журам ISO37301 стандартад нийцсэн байхын зэрэгцээ олон улсын гэрээ, бусад стандартууд, Базелийн хорооны “Банкны комплайнс болон комплайнсын чиг үүргийн тухай” зөвлөмж, Монголын Банкны Холбооны “Банкны комплайнсын бодлого, чиг үүргийн тухай” зэргийг мөрдлөг болгон ажиллахаар боловсруулагдсан ба зөвхөн Комплайнсын нэгж дангаар бусад банкны холбогдох газар, нэгжүүд комплайнсыг үйл ажиллагаа бүрд, шат шатандаа хэрэгжүүлэх давуу талуудыг бий болгосон.

Үүнээс гадна, “ХХБ-ны Ёс зүйн дүрэм”, “ХХБ-ны Шүгэл үлээх бодлого”, “ХХБ-ны авлигын эсрэг бодлого” зэрэг заавар журмуудыг батлан, холбогдох газар нэгжүүд болон хороогоор дамжуулан хяналт тавин, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эдгээр ажиллагааны дүнд банк нь дотооддоо мөрдөх бодлого, дүрэм, журам, заавар нь олон улсын болоод Монгол Улсын хууль тогтоомж болон гэрээ, дүрэм стандартад нийцэж байгаа эсэхэд анхааран дотоод зохион байгуулалтыг үүсгэн ажиллаж байна.

ШҮГЭЛ ҮЛЭЭХ БОДЛОГО

ХХБ нь МУ-ын хууль тогтоомж болон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс суртахууны хэм хэмжээ, Банкны ёс зүйн хэм хэмжээнд үндэслэн Банкны ажилтны дагаж мөрдөх заавар, журам, бодлого, ёс зүйн зарчмыг тодорхойлон тогтоож, өндөр ёс зүйтэй ажлын орчин, механизмыг бүрдүүлэн ажилладаг. Банкны үйл ажиллагаа, нэр хүндэд хохирол учруулсан, учирч болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйн талаар мэдээллийг айж эмээхгүйгээр мэдээлэх орчныг бий болгон Банкны ажилтны нэр төр, алдар хүнд, Банкны ажил хэргийн нэр хүндийг хамгаалах, үүсч болзошгүй алдаа, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “ХХБ-ны шүгэл үлээх бодлого”-ыг хэрэгжүүлж ажилладаг бөгөөд энэхүү бодлого нь банкны бүхий л оролцогч талууд болох ТУЗ, Гүйцэтгэх удирдлага, ажилтнууд, гэрээ, итгэмжлэлийн үндсэн дээр Банкийг төлөөлөх, зөвлөх зэргээр Банкийг төлөөлж буй бүх иргэнд хамаарна.

Энэхүү бодлого нь шүгэл үлээгчийн эрх ашгийг хамгаалах, нууцыг хадгалах, асуудлыг шуурхай шийдвэрлэхэд чиглэгддэг. Шүгэл үлээгч нь дараах сувгуудаар шүгэл үлээх боломжтой. Үүнд:

- Ажилтан Танд программын санал, гомдол илгээх цонх
- Ёс зүйн хорооны ethic@tdbm.mn мэйл хаяг
- 1799 дотуур дугаарт
- Цаасан өргөдөл, гомдол биечлэн гаргах
- Банкны харилцагч шүгэл үлээх тохиолдолд
- 19001977, 70161988
- info@tdbm.mn

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

“ХХБ-ны Ёс зүйн дүрэм”-ийг ажилтан бүр даган мөрдөж ажилладаг ба шинээр ажилд орсон ажилтан эхний өдрөө уншиж танилцан, гарын үсгээ зурдаг. Банкны ажилтнуудын ёс зүйн хэрэгжилтэд хяналт тавих, аливаа гомдол, маргааныг шийдвэрлэх үүднээс Ёс зүйн хороо ажилладаг. Ёс зүйн хороонд өргөдөл, хүсэлт гаргасан ажилтныг “ХХБ-ны шүгэл үлээх бодлого”-ын дагуу хамгаална.

АВЛИГЫН ЭСРЭГ БОДЛОГО

“ХХБ-ны Ёс зүйн дүрэм”-ийг ажилтан бүр даган мөрдөж ажилладаг ба шинээр ажилд орсон ажилтан эхний өдрөө уншиж танилцан, гарын үсгээ зурдаг. Банкны ажилтнуудын ёс зүйн хэрэгжилтэд хяналт тавих, аливаа гомдол, маргааныг шийдвэрлэх үүднээс Ёс зүйн хороо ажилладаг. Ёс зүйн хороонд өргөдөл, хүсэлт гаргасан ажилтныг “ХХБ-ны шүгэл үлээх бодлого”-ын дагуу хамгаална.

ДОТООД АУДИТ

ХХБ-ны дотоод аудитын бодлогын дагуу дотоод аудитын үйл ажиллагаа нь банкны оролцогч талуудын эрх ашгийн төлөө байх бөгөөд байгууллагын Засаглал, Эрсдэл, Хяналтын үр дүнтэй байдалд бодитой баталгаажуулалт хийж, үнэлж дүгнэх, үйл ажиллагааг нь хэвийн байлгахад чиглэн ажиллахаас гадна цаашид анхаарах, эрсдэлтэй асуудлыг тодорхойлон банкны стратеги, үйл ажиллагаа, санхүү, нийцлийг сайжруулах зөвлөмжийг өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зэрэг зорилго, чиглэлийн дор хэрэгжиж байна.

Дотоод аудитын газар нь бодлогынхоо хүрээнд банкны засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтад хамаарах тогтвортой байдлын асуудалд зохих хэмжээнд анхаарал хандуулж ажиллаж байна. Үүнд, тайлант хугацаанд банкны зээлийн бодлого, харилцагчийн түвшинд зээлийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх Зээлийн эрсдэлийн газар (ЗЭГ)-ын үйл ажиллагаанд аудит хийхдээ банкны байгаль орчин, нийгмийн хариуцлагын (БОНХ) бодлогын хэрэгжилтэд эрсдэлд суурилсан баталгаажуулалт хийн, үнэлэлт, дүгнэлт өгч, санал зөвлөмжөөр хангаж ажиллалаа.

Түүнчлэн Дотоод аудитын газар (ДАГ) нь жил бүрийн аудитын ажлын төлөвлөгөөндөө салбар, ТТ-ийн зээлийн үйл ажиллагааг хамруулан, ХХБ-ны бодлого, журам, заавруудад БОНХ-ын эрсдэлийн үнэлгээ хийгдэхээр зохицуулсан зээлүүдийн хувьд БОНХ-ын эрсдэлийг үнэлэх, бууруулах, удирдан ажиллаж буй байдалд хараат бус баталгаажуулалт, үнэлэлт, дүгнэлт өгч, санал зөвлөмжөөр хангаж ажиллаж байна.

ЭРСДЭЛД СУУРИЛСАН ТӨЛӨВЛӨЛТ

Банкны зүгээс базелийн стандартад нийцтэйгээр өөрийн хөрөнгийн хүрэлцээтэй байдлыг үнэлэх **ICAAP** тайланг жил бүрийн давтамжтай боловсруулдаг. Тус тайлангаар банк богино болох дунд хугацааны бизнесийн стратеги, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд үүсч болзошгүй эрсдэлүүдийг дотоод аргачлалаар тодорхойлж, тэдгээрийг нөхөх хангалттай хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг үнэлдэг. Түүнчлэн банк ирээдүйд үүсч болзошгүй гадаад болон дотоод хүчин зүйлсээс хамаарсан стресс нөхцөл байдлыг тодорхойлж, тухайн нөхцөл нь банкны зээл, зах зээл, үйл ажиллагаа, хүү, төвлөрөл, хөрвөх чадвар (**ILAAP** тайлан) болон бусад эрсдэлүүдэд хэрхэн нөлөөлөхийг тооцож, өөрийн хөрөнгө болон хөрвөх чадвартай хөрөнгийн төлөвлөлтийг хийдэг.




МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, НУУЦЛАЛ

Худалдаа, хөгжлийн банк нь харилцагч болон банкны мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон улсын сайн туршлага, шалгарсан технологиудыг ашиглах, боловсон хүчин мэргэжилтнүүдээ тасралтгүй хөгжүүлэх зэрэг үйл ажиллагаанд онцгой анхаарал хандуулан, Банкны алсын хараа, эрхэм зорилго, урт болон дунд хугацааны стратегийн зорилгод тулгуурлан сайжруулж, банканд учирч болох эрсдэлүүдийг урьдчилан тодорхойлон, тасралтгүй аюулгүй байдлын үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

Бид олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөндлөнгийн аудитын байгууллагаар мэдээллийн аюулгүй байдлын үйл ажиллагаа болон банкны дэд бүтэц сүлжээ, сервер систем, тоног төхөөрөмжийн нууцлал аюулгүй байдлыг хангах үүднээс жил бүр төлбөрийн картын аюулгүй байдлын PCI DSS (Payment Card Industry Data Security Standard) стандартын шаардлагуудыг бүрэн хангаж, баталгаажуулалтыг хийлгэн ажиллаж байна.

Мэдээллийн аюулгүй байдлын газар, түүний харьяанд Мэдээллийн системийн аюулгүй байдлын хэлтэс, Кибер аюулгүй байдлын хэлтэстэй бөгөөд аюулгүй байдлыг чиглэл бүрээр мэргэшсэн мэргэжилтнүүдээс бүрдсэн бүтэцтэйгээр банкны мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлэн, харилцагчийн мэдээллийг хамгаалж, системийн аюулгүй байдлын үйл ажиллагааг тасралтгүй ханган ажиллаж байна.

Мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг олгох чиглэлээр дотоод ажилтнууд болон, банкны нийт харилцагч нарт цахим эрсдэлээс сэргийлэх, аюулгүй байдлын ойлголт мэдлэгийг дээшлүүлэхэд анхааран тогтмол үйл ажиллагааг явуулж байна. Бид банкны тасралтгүй үйл ажиллагаа, харилцагчид хүргэж буй санхүүгийн болон цахим бүтээгдэхүүн үйлчилгээг найдвартай хүргэх, тэдгээрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах сайжруулах чиглэлээр сүүлийн үеийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын процесс үйл ажиллагааг автоматжуулах, кибер халдлагаас хамгаалах системүүд болон мэдээллийн аюулгүй байдлын хяналт удирдлагын төвийг бий болгон үйл ажиллагааг улам сайжруулан ажиллаж байна.





ХАВСРАЛТ

БҮЛГИЙН АГУУЛГА

- SASB индекс
- БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамжийн үзүүлэлтүүд
- GRI индекс

SASB ИНДЕКС

Сэдэв	Индикаторууд	Код	Тайлагнал	Нэмэлт
